

ТЭРБУМ МОД

BILLION TREES



САЯ МОД УРГУУЛСАН ТУРШЛАГА ХОЁР САЯ ДАХЬ МОДОО ТАРИХ ТЭМҮҮЛЭЛ

Соёлын гавьяат зүтгэлтэн, Хөдөлмөрийн баатар
Чинагийн ГАЛСАН



ТОЙМ СЭТГҮҮЛ



www.billiontreesmongolia.com



Төв аймаг
Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газар. Мэлхий хад
Зурагчин Ж.Доржпүрэв. 2021 он

Редакцийн зөвлөл:

С.Энхжаргал

Азийн Хөгжлийн Банкны “Тогтвортой хүртээмжтэй хөгжлийг дэмжих” (ТТ6831-МОН) төслийн зөвлөх

Д.Ариунцэцэг

Азийн Хөгжлийн Банкны “Тогтвортой хүртээмжтэй хөгжлийг дэмжих” (ТТ6831-МОН) төслийн зөвлөх

П.Болдбаатар

“Тэрбум мод” НҮТББ-ын захирал

Б.Мөнхзаяа

“Тэрбум мод” НҮТББ-ын менежер

Б.Булган

“Тэрбум мод” НҮТББ-ын менежер

А. Төрмөнх

“Тэрбум мод” НҮТББ-ын менежер



ТЭРБУМ МОД
Үндэсний хөдөлгөөн

7771-7707

info@billiontrees.mn

billiontreesmongolia.com

“Алмазпресс” хэвлэлийн газарт хэвлэв
2025 он

ГАРЧИГ

- 04 ӨМНӨТГӨЛ
- 05 ЕРӨНХИЙЛӨГЧИЙН МЭНДЧИЛГЭЭ
- 06 НҮБ-ын цөлжилттэй тэмцэх конвенцын Талуудын 17 дугаар бага хурлыг 2026 онд Улаанбаатар хотноо зохион байгуулна
- 08 Тэрбум мод үндэсний хөдөлгөөний бэлтгэл үе шат буюу ЭХНИЙ ГУРВАН ЖИЛД МОНГОЛ УЛСЫН ОЙН САН 8.28% БОЛЖ НЭМЭГДЛЭЭ
- 10 УУЛ УУРХАЙН КОМПАНИУД 43.7 САЯ МОД ТАРИВ
- 14 Бусад салбарыг хангалттай олон залуус сонгодог болохоор илүү хүн хүч хэрэгтэй байгаа “Ойн инженерчлэл” мэргэжлийг сонгосон
- 16 ОЙН ТӨСЛҮҮД
- 18 “Ногоон хэрэм” төслийн сүүлийн шатанд түймэрт өртсөн 630 га талбайг нөхөн сэргээжээ
- 20 Монгол Улс “Ойн түншлэл”-ийн хөтөлбөрт нэгдсэн Азийн анхны орон боллоо
- 21 Говьд ус бага ашиглан мод ургуулах туршилтын төслийг амжилттай явуулж байна
- 22 ШУТИС-ийн багш, доктор, дэд профессор Д.Сэрдарам: “Нэг мод таривал нэг насны буян, хоёр мод таривал хойд насны буян” гэж өр төлж мод тарьдаг сэтгэлгээ өөрчлөгдөж байна
- 27 Банкны салбарынхан 81 төслийг 16 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэв
- 28 ОЙН ТҮЙМЭР 77.1% ӨСЖЭЭ
- 29 Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг нэгэн зорилго, нэгдмэл хүсэл тэмүүллээр хамтран зүтгэхийг уриаллаа
- 30 Цэцэрлэгт хүрээлэнгүүд байгуулагдав
- 34 Сая мод ургуулсан туршлага ХОЁР САЯ ДАХЬ МОДОО ТАРИХ ТЭМҮҮЛЭЛ
- 36 Аймаг, нийслэл 56 САЯ МОД ТАРИВ
- 38 Говьд 30 мянган заг тарьж ургуулан 80.5 сая төгрөгийн урамшуулал авав
- 41 Монгол Улс дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн эрчимтэй өртөж байгаа 10 орны нэг
- 42 Хууль хүчний байгууллагууд МОД ТАРИВ
- 44 МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН ЗӨВЛӨГӨӨ
- 46 Мод үржүүлэгчдийн тоо 32% нэмэгджээ
- 47 “Бугант нандин” ХХК мод үржүүлэг, тарилтаараа хувийн хэвшлийн байгууллагуудыг МАНЛАЙЛАВ
- 48 Дэлхий дахинд усны нөөцөө үр ашигтай удирдах сорилт тулгарав
- 50 Хашаандаа 200 мод тарьж ургуулсан ХОТЫН АЙЛ
- 52 Шашинд мод тарих тухай ямар сургаал, номлол байдаг вэ?
- 54 Шинэ Хархорум хотын бүтээн байгуулалтыг албан ёсоор эхлүүлээ
- 54 Хөвсгөл аймаг хашаандаа мод тарьсан айл өрхүүдэд УРАМШУУЛАЛ олгож эхлэв
- 55 ОЙН ГАЗАР
- 55 ОЙН САН: 19.103.221 ГА ТАЛБАЙ БУЮУ НИЙТ НУТАГ ДЭВСГЭРИЙН 12.21 ХУВИЙГ ЭЗЭЛЖ БАЙНА
- 58 “Тэрбум мод” НҮТББ

ӨМНӨТГӨЛ

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн нь Монгол орны байгаль экологийн тэнцвэрт байдлыг сэргээх, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах зорилгоор өрнөж буй улс орон даяар нэгдсэн томоохон санаачилга, үйл хэрэг гэдгийг өнгөрсөн гурван жилд хүн бүр мэддэг болжээ.

Энэхүү тойм сэтгүүлдээ 2021–2024 оны бэлтгэл үе шатанд хийгдсэн бодит ажлуудаас танилцуулах, сайн туршлагуудыг түгээн дэлгэрүүлэх, төр засгаас хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээнүүдийг нэгдсэн хэлбэрээр хүргэхийг зорилоо.

2025 оноос “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн хэрэгжилтийн шинэ шатандаа орж буй энэ үед төр, хувийн хэвшил, иргэд болон олон улсын түншүүдийн

оролцоог идэвхжүүлэх, цаашдын үйл ажиллагаанд жишиг болохуйц туршлага, загвар төслүүдийг танилцуулж буйд сэтгүүлийн ач холбогдол оршино.

Үндэсний хөдөлгөөнд манлайлан оролцож, амлалтаа биелүүлэн үр дүн гаргасан зарим төрийн байгууллага, аймаг орон нутаг, аж ахуйн нэгж, иргэд болон олон улсын хамтын ажиллагааны хөтөлбөрүүдийг онцлон тусгав.

Энэхүү сэтгүүлийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын захиалгаар, Азийн Хөгжлийн Банкны “Тогтвортой хүртээмжтэй хөгжлийг дэмжих” (ТТ6831-МОН) техникийн туслалцааны төслийн санхүүжилтээр, тус төслийн зөвлөхүүд болон “Тэрбум мод” НҮТББ хамтран эрхлэн гаргав.



Хэнтий аймаг
Яргуй хавцал
Зурагчин Г.Ган-Өлзий. 2023 он



ЕРӨНХИЙЛӨГЧИЙН МЭНДЧИЛГЭЭ

2021 онд Нэгдсэн Үндэсний Байгууллагын Ерөнхий Ассамблейн индэр дээрээс Монгол Улс “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг эхлүүлж эх дэлхийнхээ ээлтэй улс байхаа тунхаглан уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг бодитой хувь нэмэр оруулах санаачилгыг эхлүүлсэн билээ.

Энэхүү санаачилгыг дэмжиж, төрийн байгууллага, орон нутаг, аж ахуйн нэгж, иргэд гээд бүх шатны олон зуун мянган хүмүүс амлалт өгч, зарим нь сайн дурын үндсэн дээр нэгдэн оролцож буйд гүн талархал илэрхийлье. Энэ бол зөвхөн мод тарих хөдөлгөөн бус харин байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах, эх дэлхийнхээ ирээдүйд хөрөнгө оруулж буй үйл хэрэг юм.

Бид үндэсний хөдөлгөөний эхний шат болох бэлтгэл үеэ амжилттай дуусгаж, одоо хэрэгжилтийг эрчимжүүлэх шинэ үе шат руу шилжиж байна. Энэ хугацаанд:

- Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болох Ойн газар шинээр байгуулагдаж, ойн бодлого, зохицуулалтыг төвлөрүүлэн хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдлээ.

- Мод тарих үндэсний өдрүүд тогтмолжиж, зөвхөн хавар, намарт бус жилийн турш үргэлжлэх олон нийтийн үйлс болон өргөжиж, нийт 100 гаруй сая модыг тарьж ургуулаад байна.

- Мэргэжлийн байгууллагууд тарьсан модыг арчилж ургуулах ажлыг үр дүнтэй зохион байгуулж, манлайлан оролцож байна.

- Мод үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг нэгжүүд эрчимтэй нэмэгдэж, үр, суулгацын нөөц 2021 онтой харьцуулахад дөрөв дахин өссөн байна.

- Монгол орны ой модны унаган чанарыг хамгаалах, хадгалах, шинжлэх ухааны үндэслэлтэй ажиллах зорилго бүхий “Ойн генетик нөөцийн төв” байгуулагдсан зэрэг нь бодит амжилтууд юм.

Тэр дундаа мод тарьж, арчилж ургуулах ажилд Батлан хамгаалах яам, Хилийн цэрэг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, Цагдаагийн ерөнхий газар болон бусад мэргэжлийн байгууллагууд идэвх зүтгэл, хичээл чармайлт гарган оролцсонд талархал илэрхийлье.

Монгол Улсын ногоон ирээдүйд үнэтэй хувь нэмрээ оруулж буй олон улсын байгууллага, гадаадын түншүүд, алс оронд суугаа монголчууд, эх дэлхийдээ элэгтэй иргэн бүрд талархал илэрхийлье.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн бол эхлэл. Бид нэг тэрбумаар тогтохгүй, тэрбум тэрбумаар тоологдох мод тарьж, ургуулж, үр өгөөжийг нь үр хойчдоо өвлүүлэх бүрэн боломжтой гэдэгт итгэж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч
Ухнаагийн Хүрэлсүх

НҮБ-ын цөлжилттэй тэмцэх конвенцын Талуудын 17 дугаар бага хурлыг 2026 онд Улаанбаатар хотноо зохион байгуулна

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 79 дүгээр чуулганы Ерөнхий санал шүүмжлэлд үг хэлэв

Миний бие Ерөнхий Ассамблейн чуулганд оролцох бүрдээ НҮБ-ын төв байрны цэцэрлэгт хүрээлэнд байдаг Монголын нэрт уран бүтээлчийн бүтээсэн “Ухамсар” хэмээх баримлыг зорин очих дуртай. Энэхүү баримал дээр очих бүрд бид бүхэн хүн төрөлхтний түүх, ирээдүй хойч үеийнхээ өмнө хариуцлагатай, ухамсартай, нэр төртэй байх ёстой гэдгийг эргэцүүлэн бодох гүн гүнзгий мэдрэмжийг төрүүлдэг юм. Гүн утга төгөлдөр энэхүү баримлыг дэлхийн улс орнууд “Тогтвортой хөгжил-2030 хөтөлбөр”-ийг баталсан, Парисын уур амьсгалын хэлэлцээр хэмээх зорилтыг дэвшүүлсэн түүхэн цаг үеийн бэлгэдэл болгон бүтээсэн. Энэ удаа очиход энэхүү гайхамшигт бүтээл Та бидний ирээдүй хойч үеийнхээ төлөө дэвшүүлсэн зорилт, амлалтын хариуг нэхэх мэт дүнсийн зогсож харагдлаа.

Энэхүү бодит нөхцөл байдлыг дүгнэн цэгнэж, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад шинэ эрч хүч өгч, үйл ажиллагаагаа улам эрчимжүүлэх зорилгоор НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гутерреш “Ирээдүйн асуудлаарх дээд түвшний уулзалт (Summit of the Future)”-ыг санаачлан зохион байгууллаа. Уулзалтаар хэлэлцэн батлагдсан “Ирээдүйн төлөө гэрээ (Pact for the Future)”, “Ирээдүй хойч үеийн асуудлаарх тунхаглал (Declaration on Future Generations)”, “Дэлхий нийтийн цахим хөгжлийн гэрээ (Global Digital Compact)” зэрэг баримт бичгийг боловсруулахад Монгол Улс идэвх санаачилгатай оролцсоныг тэмдэглэн хэлэхэд таатай байна.

Эдүгээ хүн төрөлхтний амьдрал техник, технологийн дэвшил, цахим хөгжлийн эринд асар хурдтай хувьсан өөрчлөгдөж, харилцан хамааралтайгаар хөгжин дэвшиж байна. Энх тайвныг тогтоох, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх, бүх нийтийн эрүүл мэндийг хамгаалах, эдийн засгийн тэгш бус байдлыг бууруулах, шударга ёсыг тогтоохын тулд эрин үеийнхээ өөрчлөлт, хэмнэлийг мэдэрсэн зөв зүйтэй шийдлийг олж, бүтээлч хамтын ажиллагаа өрнүүлэх шаардлага олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө зүй ёсоор тавигдаж байна.



Дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлт нь байгаль, цаг уур, эдийн засгийн хүрэнээс хальж хүний нийгмийн эмзэг асуудал, нөөц баялгийн төлөөх маргааныг хурцатгах, шилжилт хөдөлгөөнийг өдөөх зэргээр олон тооны шууд ба дам аюул, эрсдэл дагуулах боллоо. Хэрэв нөхцөл байдал энэ хэвээр удаан үргэлжилбэл хүн төрөлхтөнд хөгжих, эс хөгжихийн тухай бус, харин орших, эс оршихын сонголт тулгарахыг үгүйсгэх аргагүй.

Тиймээс та бид нөхцөл байдалд нухацтай дүгнэлт хийж, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн асуудал, сорилтуудыг даван туулахдаа эрин үеийнхээ дэвшилд суурилсан ухаалаг шийдэл, шинэ технологийг нэвтрүүлж, сайн туршлагаа харилцан хуваалцаж, хамтран ажиллах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.



Монголчууд бид нүүдэлчдийн үр сад бөгөөд энэ онцлог өв соёл, уламжлалаа өнөө ч хадгалж, эрхэмлэн дээдэлж ирсэн. Нүүдлийн соёл иргэншлийн эх сурвалж нь чухамдаа байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах, үр шимийг нь зөв зохистой хүртэх, хүн байгалийн зүй тогтлыг хадгалан хамгаалах ногоон хөгжлийн үзэл санаа юм. Энэ нь ногоон хөгжлийн ирээдүйн талаар монголчууд бидэнд уламжлалт арга ухаан, санал санаачилга багагүй байна гэсэн үг.

Тиймээс тогтвортой хөгжлийн зорилтуудыг ханган хэрэгжүүлэх хүрээнд Монгол Улс “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого, чиглэлдээ нийцүүлэн “Тэрбум мод”, “Хүнсний хангамж, аюулгүй байдал”, “Эрүүл монгол хүн”, “Цахим Монгол” зэрэг үндэсний хөдөлгөөн, хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлж байна. Эдгээр нь тогтвортой хөгжлийн

зорилгуудыг ханган хэрэгжүүлэхэд олон улс, бүс нутгийн түвшинд бидний оруулж буй хувь нэмэр гэж үзэж болно.

Энэ хүрээнд Монгол Улсын санаачилгаар НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас баталсан “2026 оныг Бэлчээр ба нүүдлийн мал аж ахуйн олон улсын жилээр зарлах тухай” тогтоолын хэрэгжилтийг хангах, НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцын Талуудын 17 дугаар бага хурлыг 2026 онд Улаанбаатар хотноо зохион байгуулахаар бэлтгэлээ хангаж байгааг дуулгахад таатай байна. Олон улсын хамтын нийгэмлэг, гишүүн улс орнууд биднийг дэмжиж, хамтран ажиллана гэдэгт итгэлтэй байна.

Мөнх тэнгэр хүн төрөлхтөн биднийг өнө мөнхөд ивээж, даян дэлхий амар амгалан байх болтугай.

Тэрбум мод үндэсний хөдөлгөөний бэлтгэл үе шат буюу

ЭХНИЙ ГУРВАН ЖИЛД МОНГОЛ УЛСЫН ОЙН САН 8.28% БОЛЖ НЭМЭГДЛЭЭ

Тэрбум тэрбумаар... Ургуулж, хамгаалж, үр хойчдоо өвлүүлнэ...

Тэрбумаар тоологдох мод тарьж ургуулах хөдөлгөөн хүн бүрийн оюун санаанд байгаль эхээ хайрлах үндсийг тарьж байна. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг Монгол Улсын Ерөнхийлөгч 2021 оны 10 дугаар сарын 4-ний өдөр “Засгийн газарт чиглэл өгөх тухай” зарлиг гаргаснаар эхлүүлж байв.


Эх дэлхий, байгаль орчноо хайрлан зохицон амьдрах монгол уламжлал, зан заншлаа эрхэмлэн, дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, ой, усны нөөцийг хамгаалж, нэмэгдүүлэх экологийн тэнцвэрт байдлыг хангахыг уг зарлигаар чиглэл

болгож үндэсний хэмжээнд 8 настай бяцханаас 80 настай буурал хүртэл бүгд нэгдэж, мод тарих хөдөлгөөний амлалтууд хөрсөнд сууж эхэлсэн юм.


Монгол Улсын Шадар сайдын ахалсан Уур амьсгалын үндэсний хорооны 2023 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор “Тэрбум мод үндэсний хөдөлгөөний стратеги, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан. Төлөвлөгөөнд “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг 2021-2024 онууд хүртэл “бэлтгэл”, 2025-2027 онуудыг “эрчимжүүлэх”, 2027-2030 онуудыг “тогтвортой үргэлжлэх” гэсэн 3 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр тусгасан.

"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнд:

21 аймаг, нийслэл нийт **680.0 сая**



Уул уурхайн томоохон 21 аж ахуйн нэгж, байгууллага нийгмийн хариуцлагын хүрээнд **608.5 сая**



Банк санхүүгийн 17 мэргэжлийн холбоо, аж ахуйн нэгж **88.6 сая**



Бусад санаачилгын хүрээнд **149,8 сая** мод тарьж ургуулахаар нэгдсэн.





“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлж эхлэх үед Монгол улсын ойн сангийн ойрхог чанар 7.96 хувь байсан бол 2022 онд 8.07 хувь, 2023 онд 8.18 хувь болж нэмэгдэв.


Тодруулбал “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн өрнөсөн 2021- 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд Монгол орны ойн сангийн ойгоор бүрхэгдсэн талбай (улсын хэмжээний ойрхог чанар) нь нийт газар нутгийн 8.28 хувийг эзэлж байна.

Таримал ой 2021 онд 7.9 мянган га талбайг хамарч байсан бол 2024 оны байдлаар 9.4 мянган га талбайд ургаж байна. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг санаачлан хэрэгжүүлж эхэлснээс хойш таримал ойн талбайн 1.5 мянган га талбайгаар нэмэгджээ.


“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2021 - 2024 онд 114.8 сая мод тарьж арчлан ургуулж, 1.9 тэрбум модыг хөнөөлт шавжид өртөн сэргэн ургах чадвараа алдахаас хамгаалаад байна.

Төлөвлөгөөний дагуу хоёр дахь үе шат буюу 2025-2027 онд “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлж 570 сая, гуравдахь шат буюу 2028-2030 онд тогтвортой үргэлжлүүлэн 850 сая мод тарьж, ургуулна.

Монгол Улс 2026 онд Улаанбаатар хотноо болох “Цөлжилттэй тэмцэх тухай НҮБ-ын конвенцын Талуудын 17 дугаар бага хурлын хүрээнд “Ирээдүйн төлөөх тогтвортой бэлчээр, газрын асуудлаарх олон улсын эвсэл” шүхэр санаачилга дэвшүүлсэн. Энэ нь уламжлалт бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг дэлхийн 100 гаруй улс орон руу чиглэсэн хөрөнгө оруулалт, санхүүжилт нэмэгдэж, 500 орчим сая хүний эрүүл мэнд, амьдралыг хамгаалж, сайжруулахад бодит дэмжлэг болно гэж үзэж байгаа юм.



МОНГОЛ ОРНЫ ОЙН ТАРХАЛТ



©themapcreators

УУЛ УУРХАЙН КОМПАНИУД 43.7 САЯ МОД ТАРИВ



Монгол улс 2030 он гэхэд нэг тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөн өрнүүлж буй. Энэ ажилд уул уурхайн компаниуд тэргүүлэх үүрэгтэй оролцож 21 аж ахуйн нэгж нийт 608 сая 500 мянган мод тарьж ургуулахаа баталгаажуулсан.

Хариуцлагын гэрээ байгуулан амлалт авсан эдгээр аж ахуйн нэгжсүүд шууд хэлбэрээр 19.8 сая мод, дүйцүүлэх хэлбэрээр 23.9 сая мод, нийт 43.7 сая мод тарьсан гүйцэтгэл 5.2 хувьтай байна.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлэх, тарьц, суулгацын нөөц бүрдүүлэх, бусад шаардлагатай хөрөнгө оруулалтыг дүйцүүлэх хэлбэрээр хийхээр “Оюу толгой” ХХК, “Эрдэнэс тавантолгой” ХХК-тай гэрээ болон санамж бичиг байгуулан ажиллаж байна.



“Оюу толгой” ХХК Зуун сая мод өвлүүлэн үлдээнэ

2021 оны 11-р сард “Оюу толгой” ХХК Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг дэмжин “Нэг зуун сая мод” тарьж ургуулах үүрэг амлалт авсан.

100 сая мод тарих хөтөлбөрийг “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний стратегитай уялдуулан 22 мянган га талбайд 63.5 сая мод биетээр тарьж, 40 сая модтой дүйцүүлэх замаар хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

Хөтөлбөрийн хэрэгжилт 2025 оны эхний хагас жилийн байдлаар 20.52 хувьтай буюу Богд уулын Түргэний ам, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сум, Өмнөговь аймаг, Үндэсний цэцэрлэгт хүрээлэн зэрэг газарт нийт 20.5 сая мод тарьж ургуулаад байна.

Түүнчлэн ойн салбарыг хөгжүүлэх, дүйцүүлэх ажлын хүрээнд,

- Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Ялбагийн хөндийн 400.4 га талбай, Дархан-Уул аймгийн Шарын гол, Хонгор суманд 215.5 га талбайд тус тус нөхөн сэргээлт хийжээ.
- Ойн салбарын дэд бүтцийг хөгжүүлэх зорилгоор 1.5 тэрбум төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмжүүдийг Засгийн газрын хэрэгжүүлэгч Агентлаг Ойн газарт хүлээлгэн өгчээ.
- Жилд 250,000- 500,000 ширхэг тарьц, суулгац ургуулах хүчин чадалтай 5 мод үржүүлгийн газрыг Өмнөговь аймгийн Ханбогд, Цогт-Овоо, Манлай, Баян-Овоо, Сэврэй суманд байгуулж байна.

Хүний нөөц, чадавх бэхжүүлэх чиглэлээр:

- 21 аймгийн 46 Сум дундын ойн ангиудын 90 гаруй ойн мэргэжилтэн, инженерүүд оролцсон сургалт, туршлага судлах “Хангайн бүсийн ойжуулалт” аялал;
- 4 аймгийн 160 гаруй байгаль орчны мэргэжилтэн оролцсон “Товийн бүсийн ургамалжуулалт” сургалт;
- Оюутны тэтгэлэгт хөтөлбөрт 2022-2025 оны хичээлийн жилд байгаль орчин, ойн аж ахуйн инженер чиглэлээр 10 оюутанд 31.7 сая төгрөгийн дотоодын тэтгэлэг олгоод байна.



“Эрдэнэс Монгол” нэгдлийн компаниуд долоон сая мод тариад байна

“Эрдэнэс Монгол” нэгдлийн хэмжээнд 291.3 сая мод тарьж ургуулах үүрэг, амлалт авч шинжлэх ухааны суурьтайгаар уур амьсгалын нөлөөллийг бууруулж экосистемд үзүүлж буй сөрөг нөлөөллийг багасгах зорилтын хүрээнд бүтээн байгуулалтын ажил өрнөж байна. “Эрдэнэс Монгол” нэгдлийн компаниуд 2025 оны хоёрдугаар улирлын байдлаар нийт 7 сая шахам мод тариад байна.

Цаашид “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд өгсөн үүрэг, амлалтыг хэрэгжүүлэх одоогийн нөөц бололцоог нэмэгдүүлэх үүднээс томоохон бүтээн байгуулалтыг эхлүүлээ.

Амлалт авсан уурхайнуудын мод тарих бололцоог нэмэхээр “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийг төлөөлөн 180 сая модыг ойт хээрийн бүс болон цөлжилт эрчимтэйгээр явагдаж буй газарт, уул уурхайн нөлөөлөлд өртөн, эвдрэлд орсон газрыг нөхөн сэргээх зорилгоор “Сая тонн - Сая мод” хөтөлбөрийг Өмнөговь, Дорноговь, Дундговь, Өвөрхангай, Завхан, Хөвсгөл, Архангай аймгуудын газар нутагт тарихаар төлөвлөжээ.

Уг төлөвлөгөөний дагуу дөрвөн улирлын турш тасралтгүй үйл ажиллагаа явуулдаг гурван мод үржүүлгийн агропарк байгуулж, нийт 936,199 ширхэг тарьц суулгац, 912 кг үрийн нөөцийг бүрдүүлээд байна.

2025 оны 2 дугаар улиралд “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн Эрдэнэс Монгол нэгдлийн бүрэлдэхүүн компани, үйлдвэрийн газрууд нэгдсэн зохион байгуулалтаар “Шинэ Хархорум” хотын байгаль орчны төлөвлөлтийн дагуу ажиллаж нийт 330 мянган ширхэг мод тарьж, “Хариуцлагатай уул уурхай - Ногоон бүс”-ийг амжилттай байгуулан 60 гаруй хувийн гүйцэтгэлтэйгээр хаврын төлөвлөгөөг биелүүлжээ.





"ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР" ТӨҮГ

"Эрдэнэт 100 сая" хөтөлбөр хэрэгжиж байна

"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын зуун сая модыг тарьж, ургуулах, үр, тарьц, суулгацын нөөц бүрдүүлэх, хөрс сайжруулах арга аргачлал, технологийг боловсруулах, үйлдвэрлэлд нэвтрүүлэх, мод тарихад ашиглагдах үржил шимт хөрсний нөөц бий болгох, жилд 10 сая шилмүүст, навчит, жимсний модны тарьц, суулгац бойжуулах мод үржүүлгийн газрыг байгуулж, мод тарих, иргэдэд экологийн боловсрол олгох, ойн сургалт, судалгаа хийх, ойн салбарын аялал жуулчлалын нэг бүтээгдэхүүн болгох зорилгоор уг төслийг хэрэгжүүлж байна.

2031 он хүртэл жил бүр 10 сая модыг Хангай болон Говийн бүсэд оновчтой төлөвлөлтөөр экосистем, эдийн засгийн үр ашигтайгаар тарьж ургуулах юм.

100 сая мод тарьж ургуулах амлалтаа хэрэгжүүлэх хүрээнд 2022-2025 онд Бэлтгэл үе шатанд:

- Ойн генетик нөөцийн "Эрдэнэт" төв
- Хөрсний инновац, технологийн "Эрдэнэт" төв
- Мод үржүүлгийн "Эрдэнэт" цогцолбор
- Шинэ Хархорум хотын ногоон байгууламжийн бүтээн байгуулалтуудад оролцож байна.

Харин мод тарих ажлыг эрчимжүүлэх 2-р үе шатанд (2025-2027 он) Говийн бүсийн мод үржүүлгийн газар, үйлдвэрлэл борлуулалт, тарилт арчилгаа хийх, 3-р үе шатанд (2028-2031 он) тарилт арчилгаа, тооллого, хяналт хийн дараах үр дүнд хүрэхээр эрчимтэй ажиллаж байна. Үүнд:

Хангайн бүс **33 сая**

Говийн бүс **30 сая**

Суурьшлын бүс **27 сая**

Хамгаалалтын зурвас **10 сая** мод тарих юм.

Бусад салбарыг хангалттай олон залуус сонгодог болохоор илүү хүн хүч хэрэгтэй байгаа “Ойн инженерчлэл” мэргэжлийг сонгосон



Юуны өмнө сургалтын тэтгэлэгт сонгогдсонд баяр хүргэе. Өөрийгөө танилцуулаач?

Би ШУТИС-ийн Ойн инженерчлэл мэргэжлийн 2-р курсээ сая төгссөн. Өнгөрсөн 2024 оны 10 дугаар сард дотоодын тэтгэлэг зарлагдсан талаар багшаасаа сонсоод шалгаруулалтад нь оролцсон. Манай ангийнхан бүгд эссэ илгээснээс би эхний шатандаа тэнцэж, дараагийн ярилцлагын шатандаа ороод шалгарсандаа маш их баяртай байгаа.

Ойн инженерийн мэргэжлийг сонгосон шалтгаан нь юу вэ? Гэр бүлийнхэн нь бас хэрхэн хүлээж авсан бэ?

Ер нь өөрөө л бодож шийдсэн. Хамаатны ах маань агрономич болвол зүгээр гэж хэлж байсан л даа. Тэгээд

“Оюу толгой” компани ойн салбарын мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөр зарлаж 2022-2025 оны хичээлийн жилд байгаль орчин, ойн аж ахуйн инженер чиглэлээр 10 оюутанд 31.7 сая төгрөгийн дотоодын тэтгэлэг олгоод байна. Тэтгэлэгт шалгарсан Шинжлэх ухаан технологийн их сургууль (ШУТИС)-ийн “Ойн инженерчлэл” мэргэжлийн 3-р курсын оюутан Ж.Элбэгсайхантай ярилцлаа.

11-р ангид байхдаа энэ талын мэргэжлүүдийг судалж үзээд экологи талдаа мэргэжилтэй болно гэж бодсон. Яг агрономич болъё гэсэн Монголд ажиллахад жаахан хэцүү юм шиг байхаар нь “ойн инженерчлэл” гэсэн мэргэжлийг нь сонгосон доо.

Ангийнхандаа ийм мэргэжилтэй болно гэж хэлэхэд шоолж байсан. “Өө чи ойн байцаагч болох гэж байгаа юм уу” гээд л. Тэгээд ЭЕШ-аа биологи, англи хэл, математикаар өгөөд энэ мэргэжлээр элсэлт авч байгаа гурван их сургуулиас ШУТИС-ийг сонгон суралцсан.

Судалж үзээд сонгосон гэж байна. Ойн чиглэлийн мэргэжлийг бусад мэргэжлээс онцгойлон сонгоход нөлөөлсөн зүйл нь юу байв?



Ирээдүйтэй санагдсан. Бусад мэргэжлээр хангалттай олон залуус суралцаж байгаа. Гэтэл ойн салбарт цөөхөн мэргэжилтэн бэлтгэгддэг юм байна лээ. Монгол орны ойн сан нь алдагдаад, цөлжилт ихсээд, экологийн ул мөр ихдэж, утаа агаарын бохирдол зэрэг олон сөрөг асуудлуудыг бодсон ч тэр энэ салбарт өөрийн хувь нэмрээ оруулан ажиллах хэрэгтэй санагдсан. Ойн салбарт илүү олон мэргэжилтнүүд хэрэгтэй. Ажлын талбар дээр ч эрэлт нь их, ирээдүйтэй мэргэжил шүү.

Ойн инженер хүн яг юу хийдэг, ямар мэргэжилтэй хүн болох вэ?

Ерөнхийдөө ойн нөхөн сэргээлт, цөлжилтийг бууруулах зэрэг хэд хэдэн чиглэлтэй. Эхний 1,2-р курстээ мод ямар чанартай, яаж ургуулбал сайн ургах уу, ургацаа хэрхэн байгальд ургуулах, ойжуулалтын талаар нэг бүрчлэн заадаг. Зөвхөн ургуулахаас гадна хортон шавж бусад хүчин зүйлээс ой модоо хамгаалах гэх мэт олон талын ажил гүйцэтгэдэг.

Монгол орны нийт газар нутгийн ердөө 8 хувийг нь л ой мод эзэлдэг. Цөлжилт маш ихтэй. Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн эхлэхдээ “9+” гэсэн зорилт гаргаж ирсэн юм байна лээ. Ойн санг 9 хувьд хүргэж нэмэгдүүлэх зорилготой. Их дээд сургуулиуд, манайх ч бас энэ чиглэл рүү анхаарч, мэргэжилтнүүдээ бэлтгэж байгаа. Сургуулиа төгсөөд ойн сангаа нэмэгдүүлэхэд л чиглэж ажиллана даа. Төгсөөд ямартай ч 1-2 жил ажиллаж байгаад дараа нь Герман руу мэргэжлээрээ магистрт суралцаж илүү туршлагатай болж ирээд нэгмөсөн салбарынхаа гүнд орж ажиллана гэж төлөвлөж байгаа.

Анх оюутан болоод энэ мэргэжлээр сурч эхлэх үеийн төсөөлөл, одоо хоёр дахь жилээ

суралцаад төгсөхөд төсөөлөл хэр өөрчлөгдсөн бэ?

Анхны төсөөлж байснаас нэлээн ялгаа гарсан шүү. Миний бодож байснаас тэс өөр байсан. Юу хийх, ямар ажлын талбай дээр очих гэх мэт. Маш их зүйл сурсан. Та бид хоёрын сууж байгаа энэ сандал, ширээний модноос хүртэл хүчилтөрөгч ялгардаг. Лакдсан модноос 40 хувийн хүчилтөрөгч ялгардаг, тоосжилтыг бууруулахад нөлөөлдөг гээд бод доо. Гэх мэт мэдлэгийн хүрээ маш их тэлж, өдөр тутмын амьдралдаа ч нэвтрүүлж, цаг үргэлж л байгаль экологидоо ээлтэй ямар ажил, ямар зүйл хийж болох уу гэдэг талаас нь хардаг болсон.

Дараа жилээс хотын бүсийн мод, бут, өсгөвөр ургац тоолох ажилд үйлдвэрийн дадлага хийх гэж байгаа. 10 жилдээ нэг удаа Монгол орны бүх мод бутыг тоолдог гэсэн. Бас болоогүй ээ цалинтай дадлага.

Чиний хувьд уур амьсгалын өөрчлөлт, агаарын бохирдол, байгалийн доройтлыг бууруулахад мэргэжилтнүүд, салбарынхан хэрхэн ажиллаасай гэж боддог вэ?

Экологийн ул мөр нэмэгдэж, газраа сэндийчээд, эргээд нөхөн сэргээхгүй орхиж байгаа байдлыг харахад их хэцүү санагддаг. Уул уурхайнууд ихсэж байгаа. Цаашид ч улам ихсэх байх. Эдгээр компаниуд нөхөн сэргээлтийг хийх ёстой. Тиймээс мэргэжлийн хүмүүсээ татан оролцуулж нөхөн сэргээлтээ гүйцэтгэл сайтай хийхэд анхаараасай гэж боддог.

Мэргэжил сонголтгоо хийх гэж байгаа дүү нартаа “Ойн инженер” мэргэжлийг сонгох шалтгаануудаас дурдаач?

ШУТИС-д 2018 оноос хойш Ойн инженерчлэл хөтөлбөрөөр нэг ч оюутан орж ирээгүй байсаар 2021 оноос хүүхдүүд энэ чиглэлээр орж ирсэн юм билээ. 2018 оноос өмнө

бол нэлээн олон буюу жилдээ 20 гаруй оюутан төгсөж байсан. Одоо бүгд Монголдоо мэргэжлээрээ сайхан ажиллаж байгаа.

Манай сургууль 1-4 курс хүртлээ 10 хүүхэдтэй. Анги бүрдэлт бага байгаа. Манай анги гэхэд дөрвөн хүүхэдтэй. Хүүхдүүд ихэнхдээ өөр анги руу шилждэг. Тэгэхээр анхнаасаа өөрөө хүсэж сонирхож орж ирвэл зүгээр шүү. Зорьж л орох хэрэгтэй. Би бол яг л өөрөө хүсэж зорьж сонгосон учраас сонирхолтой, дуртай. Шантрахгүйгээр улам сайн суралцаж төгсөөд мэргэжлээрээ ажиллана. Манай мэргэжлийн 50 хувь нь гадна ажиллах буюу модоо суулгах, тооллого хийх, газраа судлах гэх мэтээр байгальдаа байнга байдаг, нөгөө 50 хувь нь суулгасан мод бутыг компьютерт зурж оруулж дата анализ хийх гэх мэт байдаг. Ер нь олон хүнтэй байнга хамт орооцолдож ажиллахгүй, хөдөө байгальд байх, ажиллах дуртай, тарьж ургуулах сонирхолтой бол энэ мэргэжил үнэхээр гоё. Эмээ маань жимсний мод бут тарьдаг байсныг багаасаа харсаар байгаад модонд дуртай болсон.

Тэтгэлэгт хамрагдсаны давуу талууд нь юу байна?

Өөрийгөө нээж чадсан. Бас багаар ажиллаж, сайн найзуудтай болсон. Энэ тэтгэлгийн хүрээнд Залуусын хөгжлийн хөтөлбөрт хамрагдах боломжтой байдаг нь их давуу талтай. Бас сар бүр степен авч байгаа болохоор хэрэглээний мөнгө олох гэж хичээлээ цалгардуулахгүй, хичээлдээ илүү анхааран суралцаж байгаа. Манай мэргэжлээр суралцаж байх үед цалинтай дадлага хийх боломж нэлээн байдаг. Гэхдээ жаахан урт хугацаатай болохоор хичээлээ зохицуулах, төлөвлөх хэрэгтэй. Багадаа 14 хоногоос – 2 сар хүртэл байдаг болохоор зуны амралтаараа ажиллах боломжтой.

ОЙН ТӨСЛҮҮД

Ой, ойн менежментийн талаар олон улсын байгууллагууд болон Монгол улсын Засгийн газрын хамтарсан олон тооны төсөл, хөтөлбөр амжилттай хэрэгжүүлснийг онцолж байна. Зарим төслүүд үргэлжлэн хэрэгжиж буй.



Ойн салбарын хөгжлийн хөтөлбөр

Ойн тогтвортой менежментийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын экологи, эдийн засаг, нийгэм, соёлын алсын хараа, зорилгод нийцүүлэн Монгол орны ой, ойн салбарын байдал, чиг үүргийг үнэлж, тухайн зорилгод чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх боломжийг олгохын тулд ойн салбарын шинэчлэлийн талаар зөвлөмжийг Азийн Хөгжлийн Банкны шугамаар Япон улсын Засгийн газар, Азийн болон Номхон далайн бүсийн хөгжил цэцэглэл, тогтвортой байдлын төлөөх Японы сангийн буцалтгүй тусламжаар 2023 онд бэлтгэн гаргасан. Төслийн хэрэгжүүлэгчээр Финландын зөвлөх групп, Монголын ой судлалын нийгэмлэг ажилласан байна.



ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ОЙН ГАЗАР



“Өндөр хүчин чадал бүхий мод үржүүлгийн газар байгуулах, чадавхыг бэхжүүлэх нь” төсөл

Азийн ойн хамтын ажиллагааны байгууллага, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газар хамтран “Монгол Улсад “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг дэмжих зорилгоор хүчин чадал бүхий мод үржүүлгийн газар байгуулах, чадавхыг бэхжүүлэх замаар ойг нөхөн сэргээх нь” АҧСО/039/2023 төслийг амжилттай хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд Эрээний нуруунд 110 га газарт 275.000 ширхэг нарс модоор, Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн Шилжирийн амын 14 га газарт 35,000 ширхэг шинэс модоор тус тус ойжуулалт хийв.

Уг төслийн эдийн засгийн ач холбогдол нь жил бүр 3.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шууд байдлаар

- 700 саяас 1.5 тэрбум төгрөгийн тарьц суулгац,
- 7-15 сая мод буюу 280 – 600 га ой нөхөн сэргээх,
- иргэн нөхөрлөлүүд жил бүр 7-15 тэрбум төгрөгийн орлого олно.



БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



Food and Agriculture
Organization of the
United Nations

“Монгол орны хөдөө аж ахуйн менежмент, экосистемийн тогтвортой байдлыг хангах нь” төсөл

Энэхүү төсөл нь хөрс ашиглалт, тогтвортой хөдөө аж ахуй, ойн менежментийг уялдуулан уур амьсгалын сорилт, хүнсний аюулгүй байдлыг шийдвэрлэх багц арга хэмжээ хэрэгжүүлэх зорилготой. НҮБ-ын Хүнс хөдөө аж ахуйн байгууллага (FAO), Германы Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ) болон Европын Холбоо хамтран хэрэгжүүлж байна. Уг төслийн дараагийн үе шат буюу STREAM 2 төсөл 2024-2028 он хүртэл үргэлжилнэ.



БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



НҮБ-ын Ойн доройтол, хомсдолыг бууруулах REDD+ хөтөлбөр

НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн Суурь Конвенцод нэгдэн орсон улс орнууд UN- REDD+ механизмаар дамжуулан хүлэмжийн хийг бууруулах, нүүрстөрөгчийг шингээх, хадгалахын тулд бодлогын удирдамж, бодит урамшууллаар хөгжиж буй улс орнуудын ойн хомсдол, доройтлыг багасгаснаар агаар мандал дахь хүлэмжийн хийн хуримтлалыг тогтворжуулах зорилготой. Монгол Улс 2015 оноос эхлэн гурван жилийн хугацаанд НҮБ-ын төрөлжсөн гурван байгууллагын дэмжлэгтэйгээр хэрэгжиж Үндэсний бэлэн байдлын хөтөлбөрөө боловсруулсан.



БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



Food and Agriculture
Organization of the
United Nations



“Хуурай хээрийн бүсийн биологийн олон янз байдлын хамгаалал, ойн тогтвортой менежмент, нүүрстөрөгчийн шингээлтийг нэмэгдүүлэх” төсөл

Энэхүү төсөл нь хуурай хээрийн экосистемийн доройтол, биологийн олон янз байдлын алдагдлыг бууруулахын тулд олон талт оролцоот аргаар, экологид ээлтэй, зохистой менежмент, нөхөн сэргээх үйл ажиллагааг хамарна. Төслийн үндсэн ач холбогдол нь малчид, ой модны нөхөрлөл, орон нутгийн засаг захиргаа зэргийг хамруулсан “ландшафт хариуцсан менежмент”-ийн аргачлалыг боловсруулж, байгалийн нөөц, биологийн төрөл зүйлийг хамгаалах, тогтвортой ашиглах орчныг бүрдүүлэх явдал. НҮБ-ын Хүнс хөдөө аж ахуйн байгууллага (FAO), Даян дэлхийн байгаль орчны сан (GEF) болон Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF) хамтран хэрэгжүүлсэн байна.



“Монголын хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь” төсөл

Энэхүү (АДАПТ) төсөл нь уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг байгалийн нөөцөөс хамааралтай малчдын дасан зохицох чадамжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бөгөөд Ховд, Завхан, Дорнод, Сүхбаатар аймгуудыг хамран 2024-2028 онд хэрэгжинэ. Төслийн томоохон үйл ажиллагаа нь ус бүрдэх сав газрын голын татмын дагуу хийж байгаа татмын ойжуулалт юм. Дээрх дөрвөн аймгийн хэмжээнд 2,500 га талбайд татмын ойжуулалтыг хийхээр төлөвлөснөөс 2025 оны байдлаар 2,010 га талбай татмын дагуу нийт 1.2 сая мод тарьж ургуулжээ.



GREEN
CLIMATE
FUND



UN
DP



БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



Mongolian
Nature's Legacy
Foundation

The Nature
Conservancy

“Өнө Мөнхийн Монгол” хөтөлбөр

Монгол Улсын Засгийн газар, Дэ Нэйче Консерванси байгууллагын хамтарсан “Өнө мөнхийн Монгол” хөтөлбөр нь 2024-2039 он хүртэл үргэлжлэх бөгөөд улсн хэмжээнд тусгай хамгаалалттай газар нутгийг дэд бүтэц болон менежментийн үр нөлөөг сайжруулах, иргэд суурьтай байгаль хамгааллыг дэмжих зорилготой. Орон нутгийн иргэд, малчдын оролцоотойгоор ой, бэлчээр, зэрлэг амьтны экосистемийг 3 сая га талбайд хамгаалж, үр ашигтай удирдана.



БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



Korea Forest Service

“Ногоон хэрэм” төсөл

Монгол-Солонгосын хамтарсан “Ногоон хэрэм” төсөл нь цөлжилттэй тэмцэх, тоос шороо, элсэн шуургыг бууруулах, хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, түймэрт өртсөн ойг нөхөн сэргээх, кишинг болохуйц мод үржүүлгүүдийг байгуулах чиглэлээр гурван үе шаттай үйл ажиллагаа явуулж байна. 2007 оноос хойш төслийн I болон II үе шат амжилттай хэрэгжиж, III үе шат үргэлжилж байгаа бөгөөд Монголын ойн салбарын хөгжилд хувь нэмрээ оруулах, цөлжилт шар шороон шуургыг бууруулах, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг дэмжих, ойн салбарын мэргэжилтнүүдийг чадавхжуулах зэргийг чиглэл болгон ажиллаж байна.



БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

Rio Tinto



ICCF

“Эрүүл ой” төсөл

“Рио Тинто” ХХК, Олон улсын байгаль хамгаалах нийгэмлэг хамтран хэрэгжүүлсэн ойг хөнөөлт шавж, өвчнөөс хамгаалах зорилготой төсөл. 2022-2024 онд хэрэгжиж 4 сая ам.доллар зарцуулсан. Төслийн хүрээнд 1.1 тэрбум модыг мөхөх аюулаас аварч, төслийн хугацаанд нийт 300,000 га хөнөөлт шавжид нэрвэгдэх эрсдэлтэй ойн талбайг нөхөн сэргээв. “Earth ranger” хиймэл оюун ухаанд суурилсан платформыг ашиглан ойн хортон шавжийн байршил, мэдээллийг бодит хугацаанд тодорхойлох зорилгоор ойн анги, мэргэжлийн байгууллагуудад Black View 9300 pro утасны хамт түгээж мэдээлэл боловсруулах, яаралтай арга хэмжээний төлөвлөлтийг дэмжихэд бүтцийг бий болгожээ. Ажлын үр дүнд навчгүй байсан мод 4-6 долоо хоногт ногоон мод болон хувирсан байна.



БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



UN
DP

“Монголын унаган байгалийн хүлцэл, тогтворжилтыг хангах” төсөл

Монголын унаган байгалийн хүлцэл, тогтворжилтыг хангах нь (ENSURE) төслийн хүрээнд 300,000 га бэлчээр, 20,000 га сэрүүн бүсийн ой, 25 000 га заган ойг сонгож авсан газар нутагт менежментийн шилдэг арга туршлагыг нэвтрүүлэхэд чиглэжээ. ENSURE төслийн 2-р бүрэлдэхүүн хэсэг нь орон нутгийн бүлэг, нөхөрлөл дээр түшиглэж шилмүүст болон заган ойн тогтвортой менежментэд сайн туршлагаудыг нэвтрүүлэх, сум дундын ойн анги болон орон нутгийн иргэдийг чадавхжуулах замаар хэрэгжүүлж байна.

“Ногоон хэрэм” төслийн сүүлийн шатанд түймэрт өртсөн


630 га талбайг нөхөн сэргээнэ



Монгол - Солонгосын хамтарсан “Ногоон хэрэм” нь 2007 оноос эхлэн цөлжилт, шар шороон шуургыг бууруулах хамтын ажиллагааны хэлэлцээрийн дагуу үйл ажиллагаа явуулж буй Засгийн газар хоорондын төсөл юм.

Төслийн хүрээнд мод үржүүлгийн газруудыг байгуулж ойн салбарт жишиг загварыг бий болгож байна.

Төслийн I болон II үе шат амжилттай хэрэгжиж, III үе шат үргэлжилж байгаа бөгөөд Монголын ойн салбарын хөгжилд хувь нэмрээ оруулах, цөлжилт шар шороон шуургыг бууруулах, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг дэмжих, ойн салбарын мэргэжилтнүүдийг чадавхжуулах зэргийг чиглэл болгон ажиллаж байна.



Төслийн I үе шат (2007-2016)

Цөлжилт эрчимтэй явагдаж буй говь, хээрийн бүс нутгууд болох Лун сум, Даланзадгад сум, Булган сумын Баянзагт Монгол улсад тохирсон технологиор 10 жилийн турш 3,000 га-д ойжуулалт, 45 га-д мод үржүүлгийн газрыг байгуулж цөлжилт, шар шороон шуургыг бууруулах ажилд дэмжлэг үзүүлээ.

Төслийн II үе шат (2017-2021)


Төслийн I үе шатны хүрээнд ойжуулсан талбайнуудыг үе шаттайгаар Монгол Улсын Засгийн газарт хүлээлгэн өгч, Улаанбаатар хотын Дамбадаржаад 40 га талбайд “Хотын ой”-г байгуулж Улаанбаатар хотын иргэдийн амралт чөлөөт цагаа өнгөрөөх ногоон байгууламжийг бий болгожээ.



Төслийн III үе шат (2022-2026)

Цөлжилт шар шороон шуургыг бууруулах, ойг нөхөн сэргээх суурь байгууламжийг бий болгох, түймэрт өртсөн ойг нөхөн сэргээх, ойн түймрээс урьдчилан сэргийлэх системийг бий болгоно. Ингэхдээ Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Бугант тосгонд доройтсон ойг нөхөн сэргээх ажлыг эхлүүлж, түймэрт өртсөн нийт 630 га талбайг сонгож газрын зөвшөөрлийг аваад байна.

Мөн төслийн хугацаанд ойн түймрийн хяналтын камертай цамхаг, түймрийн хяналтын өрөөг тохижуулах, ойн түймэр унтраах сайн дурын анги байгуулах ажлуудыг хийж гүйцэтгэж байна.



Монгол Улс “Ойн түншлэл”-ийн хөтөлбөрт нэгдсэн Азийн анхны орон боллоо

Монгол Улс нь Ази тивээс Европын Холбооны Ойн түншлэлийн санаачилгад нэгдсэн анхны улс болж, 2022 онд Монгол Улсын Ерөнхийлөгч УХүрэлсүх болон Европын Комиссын Ерөнхийлөгч Урсула фон дер Ляйен нар харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурж эхлүүлжээ.

Санамж бичгийн гол зорилго нь ойн тогтвортой менежментийн үндсэн алхмууд болох ой модыг нөхөн сэргээх, зохистой ашиглалт, хамгаалалтыг дэмжих, ойг түшиглэсэн эдийн засгийн салбар, орлогын эх үүсвэр бий болгоход чиглэж байна.

Ойн түншлэл нь Европын Холбооны “Global Gateway” буюу тогтвортой хөгжилд чиглэсэн хөрөнгө оруулалтын стратегийн хүрээнд хэрэгжиж буй бодлогын түвшний хамтын ажиллагааны механизм юм.

“Global Gateway” стратеги болон Ойн түншлэл санаачилгыг нэвтрүүлэхдээ Монгол Улсын “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлого, Парисын хэлэлцээрийн хүрээнд шинэчилсэн Үндэсний тодорхойлсон хувь нэмэр, НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилгууд, Монгол Улсын

Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнтэй уялдуулан хэрэгжүүлж байна.

Ойн түншлэлийн зорилго нь Монгол орны ойг хамгаалах, нөхөн сэргээх, тогтвортой ашиглах, ойн салбарт ажлын байр бий болгох, хууль бус мод бэлтгэлийг бууруулж, тогтвортой үйлдвэрлэл, худалдааг дэмжихэд чиглэж байна.

Ойн түншлэлийн хүрээнд Европын Хөрөнгө оруулалтын Банкаас Монгол Улсад ойжуулалт, ногоон дэд бүтэц, уур амьсгалд тэсвэртэй ойн салбарыг хөгжүүлэх чиглэлээр 100 хүртэлх сая еврогийн хөнгөлөлттэй зээл олгож, хамтарсан санхүүжилтийн 200 хүртэлх сая еврогийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх боломжийг судалж байна.

Монгол Улс - Европын Холбооны Ойн түншлэл нь Монгол Улсад тогтвортой хөгжлийг дэмжих шинэ хөшүүрэг болов. Европын Холбооны гишүүн улсууд өмнө нь тус тусдаа төсөл хэрэгжүүлдэг байсан бол одоо Ойн түншлэлийн хүрээнд харилцан уялдаа холбоотой, нэгдсэн стратегийн хүрээнд хамтран ажиллаж, ойн салбарын шинэчлэл, тогтвортой хөгжил, ойн нөөц баялгийн доройтлыг бууруулах, нөхөн сэргээлтийг эрчимжүүлэхэд хамтдаа хувь нэмрээ оруулж байна.




Говьд ус бага ашиглан мод ургуулах туршилтын төслийг амжилттай явуулж байна

Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА), Нийгата мужийн Гадаадтай технологийн талаар хамтран ажиллах нийгэмлэг ашгийн бус байгууллагын Дорноговийг ургамалжуулах туршилтын төслийн инновац хэмээх урт нэртэй төсөл нь Дорноговь аймгийн хөрс, усны нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, модыг усалгаа багатай эхний усалгаагаар ургуулж, цаашид тогтвортой ургахуйц болгох туршилтыг Японы мэргэжилтнүүд, шинжилгээний багаж төхөөрөмжийн тусламжтайгаар хийж байна.

Усны хомсдол, асуудал ихтэй говийн бүс нутагт ус бага ашиглан мод ургуулах туршилт гэж хэлж болно.

Төслийн хүрээнд 500 модны нүх бэлтгэж тарьц, суулгац ургуулах туршилт явуулж иржээ. Хөрсний судалгаагаар ялзмагтай хөрс хэт нимгэн, харин шаварлаг хөрс нь маш хатуу гэдгийг тогтоож хөрсний энэ давхраас доош үндсийг хүргэж мод өөрөө амьдрах чадвартай болгох зорилт тавьсан байна. Суулгацын үндсийг урт болгох, агаараар тасалсан тарьц суулгах, урт үндэстэй суулгацын үржүүлгийг хийх, М-стар бортоготой тарьц, био бортоготой тарьц гэх мэт олон янзын тарьц суулгац дээр туршилтаа хийжээ.



Тухайлбал, гүн нүхэнд тарих аргыг усалгааны хоолойтой аргаар туршиж, нэг удаагийн усалтыг ахиулан хийж дахин усалж арчлахгүйгээр ургуулжээ.

Туршилт амжилттай явагдаж буй хэдий ч хатуу шаварлаг хөрсийг нэвтэлж гүн (1.5 м) нүх ухах, хоолой суурилуулах, анхны усалгааг 200-300 хүртэл литр усаар хийх зэрэг эхлэлийн зардал харьцангуй өндөр байгаа тул эдгээрийг бууруулах боломжийг туршихаар ажиллаж байгаа аж.



Тарьц суулгац үржүүлэх тавиур.

ШУТИС-ийн багш, доктор, дэд профессор Д.Сэрдарам:

“Нэг мод таривал нэг насны буян, хоёр мод таривал хойд насны буян” гэж өр төлж мод тарьдаг сэтгэлгээ өөрчлөгдөж байна



Та хэзээнээс хэрхэн модтой холбогдов?

Багаасаа буюу социализмын үед “Залуу байгальчдын станц” гэж хүүхэд багачуудад Экологийн боловсрол олгодог том төв байдаг байлаа. Улаанбаатар хотын бүх сургуулийн сурагчид тэнд ажиллаж үзсэн байхаа. Тэнд ажиллаад мод тарьж ургуулах, Улаанбаатар хотын ногоон байгууламжийг анхааралтай хардаг, модны сонирхолтой болсон байх. 20-иод жилийн өмнө БНСУ-д суралцаж байхдаа Данкуук их сургуулийн оюутны клубын идэвхтэй гишүүн байсан. Монголдоо ирээд “My club” онлайн коммунитиг оюутнуудтайгаа байгуулж мод тарих эко сайн дурын төрөл бүрийн ажлыг 19 жил тасралтгүй хийж ирлээ.

Энэ хугацаанд бидний хийсэн ажлын гол зорилго олон мод тарьж ургуулахаас илүү “хүүхдүүдийн тархинд мод тарих сэтгэлгээ суулгах” байжээ гэдгийг ойлгож байна. Өнөөдөр тантай уулзаж байгаа энэ үед “Монгени” цогцолбор сургуулийн 30 гаруй хүүхэд Сайн дурын мод тарих ажилд оролцсон сертификатаа авч байна. Өнгөрсөн жилээс

хойш надтай хамт модны ажилд явж модны тухай, үрслэгээний талбайн тухай, хөрс шороо, хүнд хэцүү болон амархан ажлын тухай тодорхой ойлголттой болж энэ хүүхдүүд маань хоорондоо нөхөрлөж, бие биедээ туслан хамтын ажил хөдөлмөр, ажлын бэрхшээлийн тухай бага ч гэсэн ойлголттой болж байна.

Монголчуудын модтой харьцдаг соёл ухаан, ургуулдаг сэтгэхүйн онцлог нь юу вэ?

Нүүдэлчин ахуй соёл байгаль дэлхийдээ сөрөг нөлөө үзүүлдэггүй, байгальд ул мөргүй амьдардаг ард түмэн бол Монголчууд байгальдаа дасан зохицож амьдардаг бидэнд ургамал тарьж ургуулан, үр жимсийг нь түүж авдаг сэтгэлгээ байгаагүй. Бэлэн ургасан өвс ургамлын үр жимсийг боловсорсон үед нь түүж хэрэглэдэг нүүдэлчдийн энэ сэтгэлгээ байгаль орчны доройтол үүсгэлгүй олон зуун жил болсон ч сүүлийн 50 хүрэхгүй жилийн хугацаанд ул мөр үлдээх нь бүү хэл сүйтгэж доройтуулаа. Тиймээс бидэнд одоогоор мод тарьж ургуулаад уулыг ой модоор

бүрхүүлсэн, ус ургамал, гол мөрнийг нөхөн сэргээж унаган байдал оруулсан түүх байхгүй, гадны туршлагаас суралцаж байна.

Өнөөдөр байгаль орчинд чин сэтгэлгээнээ ээлтэй ханддаг ухамсрыг ирээдүй үед суулгаж өгөх зайлшгүй үүрэг боллоо. Одоо бидэнд байгаль орчноо хамгаалах биш дасан зохицох, нөхөн сэргээх сэтгэлгээ хэрэгтэй болжээ. Хамгаалах зүйлгүй болсон энэ сэтгэлгээнээс нөхөн сэргээх, дасан зохицох сэтгэлгээ нь судалгаанд тулгуурласан шинжлэх ухаанч, инновацлаг, нийгэм эдийн засаг, соёл, амьдрах хэв маягт шинэ хэв маяг оруулсан сэтгэлгээ юм. БНХАУ-д хэрэгжиж байгаа Кубуки цөл төсөл үүний нэг тод жишээ.

Таны оюутан залуустаа хамгийн их хэлж, сургадаг зүйл юу вэ?

“Хэцүү ажлыг хамтаараа хийвэл хөгжилтэй”, “Ганцаараа бол хурдан, Олуулаа бол хол явна”, “Надад хэлбэл мартана, надад харуулбал тогтооно, надаар хийлгүүлбэл ойлгоно” гэсэн үгийг байнга хэлдэг. Энэ үг манай хөлөөвийн уриа. “Мод тарих сайхан, мод гоё ургана” гэж хэлэхээс илүү бидний





тарьсан мод арчлахгүй бол 40 хувь нь үхдэг. Тиймээс ургуулахын тулд хамтдаа ажиллах хэрэгтэй гэж хүүхдүүдээ уриалдаг.

Академик боловсрол, арга технологийг нь эзэмших мэдээж чухал. Гэхдээ боловсролын байгууллагууд оюутан залуусыг жинхэнэ сэхээтэн болгон бэлдэхийн тулд юун дээр анхаарах хэрэгтэй гэж боддог вэ? Орчин үед сэхээтэн гэж ямар хүнийг хэлэх вэ?

Сэхээтэн гэдэг нийгмийн эрсдэлийг илүү өмнө нь хараад, түүнээс урьдчилан сэргийлж, шүгэл үлээх ёс суртахуунтай хүмүүс байх ёстой. Өндөр боловсрол, сэхээтний буйр суурьтай хүн болгохоос илүү ЗӨВ ХҮН болгох суурь хүмүүжил манай залуу үед төлөвшөөсэй гэж хүсдэг. Хамгийн түрүүнд гэр бүлийн орчин, дараа нь сургууль, анги танхимд багш

нар нь багш биш менторууд байх нь чухал. Сайн дурын ажилд оролцдог хүүхдүүдтэйгээ жирийн найзууд байхыг хичээдэг. ЕБС-ийн хүүхдүүдэд, ИДС-ийн оюутнуудад менторууд дутагдаж байна. Менторын чадвартай хүн байхгүй ч гэсэн ядаж тэдний яриаг сонсдог итгэлтэй хүн байдаггүй. Өөрсдийгөө илэрхийлэх, санал бодлоо зоригтой чөлөөтэй илэрхийлэх орчин, орон зай тэдэнд алга. Ингэж хэлж сурна гэдэг их чухал чадвар. Яриаг нь шүүмжлэлгүйгээр, дуугүй сонсоно гэдэг түүнээс илүү чухал чадвар. Хүүхдүүдийн яриаг сонсоход заримдаа сэтгэлээр унамаар, их өрөвдмөөр байдаг. Гэр бүлийн зөрчил маргаан хүүхдүүдийн нүдэн дээр болдог учир тэд нийгмээс илүүтэй гэр бүлийн орчноосоо шарх авдаг. Ийм энгийн зүйлд анхаарахгүй том том төсөл, бодлого яриад суудаг бид даанч ичмээр хүмүүс.

Ер нь мод тарихад хэр их хөрөнгө мөнгө шаардагддаг вэ? Та 19 жил мод тарихад хэр хөрөнгө зарцуулсан бэ?

Маш их мөнгө хөрөнгө, цаг хугацаа зарцуулсан. Түүнийг үнэлшгүй. Модыг ямар өртгөөр тарьж ургуулах вэ? гэдэг эдийн засгийн тооцооноос илүү хэр их сэтгэл шингэх вэ? гэдэг сэтгэлгээ чухал. Та өөрийнхөө хүүхдийг “Энэ миний 5 сая эсвэл 500 сая төгрөгөөр өсөж хүмүүжсэн хүүхэд” гэж хэлэхгүй биз дээ. Зарим нь 500 сая төгрөг ч зарцуулалгүй өөрийнхөө гудамжинд хүн болж өссөн хүүхэд байгаа. Тэд адилхан агаараар амьсгалж, адил орчинд харилцаанд орж бие биедээ нөлөөлдөг шиг мод тарих ажлыг эдийн засгийн хөшүүрэг, тооцоолоор харахаас гадна модонд хандах сэтгэлгээ их чухал гэж хүмүүст ойлгуулахыг хичээдэг. Шаардлагатай үед өөрийнхөө

хөрөнгө мөнгө, амиа ч зориулж чаддаг сэтгэлтэй хүмүүст байгаль дэлхий хариу өгөөжөө өгнө. Ийм тогтолцоо бүрдсэний дараа байгаль орчинд бага, бас бодитой зардал зарцуулж болдгийг бас л нөгөө хэлэх дуртай Кубуки цөл төслөөс харж болно.

Уур амьсгалын өөрчлөлтийн асуудал зөвхөн Монгол биш хүн төрөлхтний тулгамдсан асуудал болчихлоо. Гэтэл бид нэг л хол мэтээр санаад байх шиг?

2007 онд Цахим өртөө сүлжээний андууд "2070 оноос ирсэн захиа" гэдэг цахим захидал орчуулж анх онлайнаар цацаж байлаа. Тэр захидалд өдөрт нэг аяга ус уух зөвшөөрөлтэй, цалингаа мөнгөөр биш усаар авдаг гээд тэр үед төсөөлшгүй олон зүйл 20 хүрэхгүй жилийн дотор биеллээ олж байна. Өнөөдөр ийм контентууд их олон сувгаар цацагдаж хүмүүс усаа хайрлаж хамгаалах талаар боддог

болсон ч тийм аюул арьсан дээр нь ирээгүй нөхцөлд бодит ажил хийхгүй л байгаа. Хүн гэдэг харх шиг байгаль экологийн доройтолд дасан зохицож, амьдралын чанар нь муудаж байгааг анзаардаг өөрт хэрэгтэй бодит шийдлийн төлөө ганцаараа ажиллаж чаддаггүй. Японд +40 хэм хүрч халж хүмүүс амь насаа алдаж байгаа нь хэсэг хугацааны дараа мартагдах зүгээр нэг мэдээ болж хүмүүс дасаж байна. Улаанбаатараас 20 км гараад цэвэр агаар амьсгалж байгаа, эсвэл хүйтний 6 сард тэсэж бохир агаарын улирлыг өнгөрөөж байна гэдэг нь хамгийн тулгамдсан асуудал. Амьдралын чанарын энэ доройтол мөдхөн бидний арьсан дээр ирж нүүр тулна.

Та Монголын ирээдүйд, хүүхэд залуустаа хэр итгэдэг вэ?

Маш их итгэдэг. Тэд ямар байгаа нь чухлаас илүү тэдэнд

итгэж найдахаас өөр аргагүй. Энэ хугацаанд олон хүнтэй хамт мод тарьсан. Ихэнх нь мод тарьж зураг авхуулаад, модоо арчлахаа мартдаг. Бид ингэж өнгөц хандаж байхад хүүхдүүд өөр байна. Тэд хамтдаа ажиллахдаа жаахан ч болов сэтгэлгээний эерэг өөрчлөлт гарч байгаа болов уу? гэж найддаг. Хөлөөв маань "Хүүхдүүдийн цэнхэр галт тэрэг, би түүний жолооч нь" тэд галт тэрэгтээ суугаад хөгжил баясалтай зорчиж байгаад буух буудал дээр бууна. Хэдэн буудал явах, хэн байх нь надад чухал биш гал тэрэгт маань зорчигчид дүүрэн байх нь чухал. Ийм замаар 19 жил явчихсан. Тоолохын эцэсгүй олон хүүхэдтэй хамт ажиллаж үзэв.

"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн ч гэсэн хүүхдүүдийн сэтгэлгээнд нэг зүйл суулгаж байгаа нь тодорхой. Модонд зөв хандлагаар ханддаг болж байна. Мод гэдэг зүгээр түлээ биш юм байна, хүн бүр нэг мод тарьчих юмсан гэсэн сэтгэлгээтэй болж байна.

Өмнөх "нэг мод таривал нэг насны буян, хоёр мод таривал хойд насны буян" гэсэн өр төлбөр төлж мод тарих гэсэн буруу ойлголт өнөөдөр өөр болж байна. Гэхдээ "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн тодорхой төлөвлөгөө, төлөвлөлттэй, хүрэх үр дүн зарцуулах төсөв, түүнийг хэрэгжүүлэх дүрэм журам бүхий ТЗЗҮ чухал үүрэгтэй. Гадны хамтрагч байгууллага, хувь хүн, улс орон энэ төлөвлөгөөгөөр хамтран ажиллана.

Хятадад хиймэл оюун ухаантай роботоор мод тарьж байна. Хажууханд говь цөл газарт ойн төгөл бүтээсэн ноу хау, туршлага Кубуки цөлийг сэргээж, амьтдын төрөл зүйлүүд нэмэгдэж, системтэй шийдлүүд бүгд хийгдэж бизнес модел нь НҮБ-ын жишиг хөтөлбөр болсныг манай улс шууд хуулж авах боломжтой.





Монгени цогцолбор сургуулийн 11.В ангийн сурагч

Ц.Тамир

Багш маань яг л найз шиг байж, хэнийг ч ялгаварлахгүй, ижил тэгш байр сууринаас ханддаг нь надад их сэтгэгдэл

төрүүлсэн. Номын баярт очсон ч тэр бидэнд гоё ном авч бэлэглээд, өөрт байгаа бүхнээ хуваалцдаг эдгээр чанарыг өөртөө авч үлдсэн. Учир нь би digital journalist мэргэжлээр суралцана гэж бодож байгаа. Ард түмэн, улстөр байгаа цагт сэтгүүлч хүн “ард түмний дуу хоолой” болох ёстой. Нийгэмд дутуу үнэлэгддэг салбар, дутуу үнэлэгддэг хүмүүсийн дуу хоолой болж ажиллана гэж бодож байгаа. Энэ бодол мөрөөдөл рүүгээ тэмүүлэхэд сайн дурын ажилд оролцсон өдөр сарууд их урам зориг өглөө.

Мод тарьж байхдаа байгалиасаа авч байгаа зүйлээ буцаагаад шингээж өгч байна гэж бодон улам эрч хүч авч, насан туршдаа мод тарьж аричлж явах сэтгэлгээтэй болсон.



Монгени цогцолбор сургуулийн 12.Г ангийн сурагч

Н.Мишээл

Бидний өөрсдийн хийж байгаа үйлдэл, хог хаягдлаас болж дэлхийн уур амьсгалын өөрчлөлт бий болох,

озоны давхарга нимгэрэх асуудал үүсэж байгаа. Энэ бүхэн байгальтайгаа хэрцгий муухай, хайнга хандсанаас л болж байна. Тиймээс хүн бүр мод тарих хэрэгтэй. Улаанбаатар маань илүү өнгөлөг гэгээлэг, хүчилтөрөгч сайтай, бүх хүн стрессгүй, эерэг энергитэй байя гэвэл илүү их мод тарих хэрэгтэй гэж боддог. My club-ын сайн дурын ажилд оролцож модыг илүү нягт ойлгож тарьж эхэлсэндээ маш их баярлаж байгаа. Мод гэдэг бидэнтэй адил амьтай. Үндсийг нь суулгаад тавьчихдаг зүйл биш. Бүр сэтгэлээсээ тарих хэрэгтэй. Шороо нь ямар байх, ямар нүх ухах гээд бүх зүйлийг судалж мэдэж тарихгүй бол мод зөв ургахгүй.

Яаж тарих нь чухал. Хамт олонтойгоо олуулаа мод таривал уур амьсгал илүү гоё дулаан байж мод нь илүү гоё ургах магадлал ихтэй гэж бодож байна.



БГД-ийн Монгени цогцолбор сургуулийн 11.В ангийн сурагч

С.Алтанбагана

Баг хамт олноороо бөөндөө сайн дурын ажил хийгээд хүмүүст тусалж байгаа нь гоё. Тэгээд өөрийнхөө ирээдүйд хэрэгтэй зүйлээр

шагнуулж байгаа нь бүр ч гоё санагддаг. Мод тарих тухай огт мэддэггүй байснаа бодоход одоо нэлээн мэдлэгтэй болсон. Мод ургамлыг хайрлаж сурсан. Бас найзуудтайгаа хамт хийсэн болохоор хөгжилтэй сонирхолтой байсан. Би өөрийнхөө амьсгалах агаарыг тарьж байна, цаашдаа миний тарьсан модоор миний хүүхдийн хүүхэд бид бүгд амьсгална гэж бодохоор сайхан байна.



Монгени цогцолбор сургуулийн “Интракт” клубын сурагч

О.Цэнгүүн

Манай клубынхан дөрөвдүгээр сараас хойш долоо хоног бүр тасралтгүй мод тарих сайн дурын ажилд явж байгаа. Олуулаа

хөрсөө бэлдээд, модоо суулгаж тарьж байгаа маань маш дурсамжтай үйл явдал. Дараагийн удаад мод тарих нарийн мэдлэгтэй болж үлдсэндээ баяртай байгаа. Бас “Хөөрхөн зулзага” төв дээр очиж амьтдад тусалж, ой цэвэрлэх гээд байгаль экологийн олон үйл ажиллагаанд оролцсон. Ээж маань байгальд ээлтэй ажил мэргэжилтэй хүн болоорой гэдэг. Тэрийг нь санаж явдаг.



Монгени цогцолбор сургуулийн 10.Д ангийн сурагч

Б.Эрдэнэболд

Мод тарих ажлыг зөвхөн сертификат авахын тулд биш хүмүүст, байгальд сайн үйлс хийсэн нь надад маш сайхан санагдсан. Бас би

илүү нээлттэй болоод байгаа. Сэтгэл онгойгоод. Мод тарих талаар бага байхдаа тоодоггүй байсан одоо бол илүү ухамсартайгаар боддог болсон. Нэг хүн ч гэсэн мод тарьж байгаа нь бахархмаар зүйл.

Банкны салбарынхан 81 төслийг 16 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэв



“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд банк, санхүүгийн салбар, мэргэжлийн холбоод болон зарим аж ахуйн нэгж нэгдэж 2030 он гэхэд 88 сая мод тарьж ургуулахаа баталгаажуулсан.

Түүнчлэн Монголын банкны холбооны гишүүн байгууллагууд “Тэрбум мод” санд жил бүр хоёр тэрбум төгрөгөөс багагүй хэмжээний хандив өгөхөөр болсон. Мөн банкны салбарын хэмжээнд ногоон зээлийг 2030 он гэхэд 10 хувьд хүргэж, таван их наяд хоёр зуун тэрбум төгрөгийн зээл олгоно.

“Тэрбум мод” сан 2023, 2024, 2025 оны зарласан төсөл сонгон шалгаруулалтаа олон улсын сангуудын зарчмаар ил тод, нээлттэй, хараат бус байдлаар, салбарын 20 гаруй экспертүүдээс бүрдсэн багийн тусламжтайгаар 7 үе шаттайгаар төслүүдээ сонгожээ.

Үр дүнд нь Монголын банкны холбоо, арилжааны

банкууд болон Монгол банкны хамтран байгуулсан “Тэрбум мод” сангаас 2023 онд 34, 2024 онд 47 нийт 81 төсөлд буцалтгүй санхүүжилт олгож, 1089 га талбайд 3 сая гаруй мод тарьж, 72+ ажлын байрыг бий болгожээ.

Эдгээр төслүүдэд өнгөрсөн гурван жилд нийт 16 тэрбум төгрөгийн санхүүжилт олгов.

2025 онд санхүүжилт олгох төслүүдээ сонгон шалгаруулан, их хэмжээний ой нөхөн сэргээлтийн төслүүдийг хэрэгжүүлэх замаар үйл ажиллагааны хүрээгээ тэлж Монгол орны ойн салбарт тогтвортой хөгжлийг бий болгоход хувийн хэвшлүүдээ түүчээлэн ажиллаж байна.

ОЙН ТҮЙМЭР 77.1% ӨСЖЭЭ




Нийт нутаг дэвсгэрийн 55.6 хувь нь ой, хээрийн түймэрт өртөж байна

Улсын хэмжээнд он гарсаар (2025.07.02)-ны өдрийн байдлаар 149 удаагийн ой, хээрийн гал түймэр бүртгэгдлээ. Энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад ойн түймэр 77.1 хувиар, хээрийн түймэр 16.9 хувиар өссөн байна.

Дээрх түймрийн улмаас урьдчилсан байдлаар 663,317 га талбай, таван байшин, 49 гэр, таван автомашин, долоон мотоцикл, 125 малын ашаа, 5937 боз, 470 бод мал, 7980 боодол өвс, 80 шуудай тэжээл өртөж, 6 тэрбум төгрөгийн хохирол учирчээ.

Онцгой байдлын ерөнхий газраас Азийн Хөгжлийн Банкны дэмжлэгтэйгээр Ядуурлыг бууруулах Япон сангийн санхүүжилтээр “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ, төлөвлөлт болон эрсдэл шилжүүлэх чадавхыг бэхжүүлэх” техник туслалцааны төслийг хүрээнд Монгол Улсад зонхилон тохиолддог гамшгийн 10 төрлөөр эрсдэлийн үнэлгээ хийж, нийт 1500 орчим зураглалыг боловсруулсан.

Тус төслийн хүрээнд боловсруулсан “Монгол орны ой, хээрийн түймрийн эрсдэлийн үнэлгээ”-ний зураглалыг гаргажээ.



Монгол орны хувьд ойн экосистемийн орон зай - цаг хугацааны динамикийг тодорхойлдог гол хүчин зүйл бол ойн түймэр. Судалгаагаар манай орны нийт нутаг дэвсгэрийн 55.6 хувь нь ой, хээрийн түймэрт өртөж байгаа бөгөөд жил бүр 80-100 тал хээр, ой хээрийн түймэр ихэвчлэн 3-6-р саруудад гардаг байна.

Хээрийн түймэр нь бэлчээрт их хэмжээний эдийн засаг, экологийн хохирол учруулдаг. Тухайлбал, хээрийн түймэр нь ялзарсан өвс, ургамлууд, бут сөөгийг шатааж, хөрсний чанарыг бууруулж, органик бодисыг устгаж, хөрсний элэгдэлд хүргэдэг. Тал хээрийн түймрийн шалтгааныг байгалийн, хүний санаатай үйл ажиллагааны үр дүнд, эсвэл санамсар болгоомжгүй үйл ажиллагааны үр дүнд гэсэн гурван төрөлд ангилдаг.

Нийт бүртгэгдэж байгаа ой, хээрийн түймрийн 70 орчим хувь нь хүний буруутай үйл ажиллагаанаас үүджээ. Ойн түймрийн гамшиг хэдэн арван жилдээ үргэлжилдэг. Оволзсон түймрийн голомтыг унтраахаар онцгой байдлын албан хаагчид, аврагчид амь биеэ үл хайхран ордог. Хэдийгээр тэдний үүрэг боловч аминаас илүү үнэтэй зүйл нь байгаль дэлхийгээ хайрлах сэтгэл, бусдын төлөө гэсэн эр зориг аж. Түймрийн эсрэг зөвхөн гал сөнөөгчид, албан хаагчид тэмцэхгүй. Эх орныхоо эзэн нь болсон та бид илүү хариуцлагатай, ухамсартай байх учиртай.

Алдсан галыг тогтоон барих хэцүү ч, алдахгүй байх боломж та бидний гарт бий.



Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг нэгэн зорилго, нэгдмэл хүсэл тэмүүллээр хамтран зүтгэхийг уриаллаа

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор “Тогтвортой байдлын яриа хэлэлцээ 2025 – Уур амьсгалын өөрчлөлт: Тэрбуман мод” чуулга уулзалт Төрийн ордонд болов.

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх чуулга уулзалтыг нээж үг хэллээ. Тэрбээр, уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, газрын доройтол, орчны бохирдол зэрэг байгаль орчны тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд улс орнууд, бүс нутгийн хамтын ажиллагаа, харилцан ойлголцол, нэгдмэл байр суурь, нэгдсэн дуу хоолой нэн чухал гэдгийг онцлолоо.

Монгол Улс дэлхийн улс орнууд, олон улсын байгууллагууд, донор болон хөгжлийн түншүүдтэй бүх талаар нээлттэй, харилцан ашигтай, үр дүнтэй хамтран ажиллахын төлөө байгааг илэрхийллээ. Мөн байгаль дэлхийгээ хайрлан хамгаалж, хойч үедээ ногоон ирээдүйг өвлүүлэн үлдээхийн төлөө нэгэн

зорилго, нэгдмэл хүсэл тэмүүллээр хамтран зүтгэхийг уриаллаа.

НҮБ-ын 8 дахь Ерөнхий нарийн бичгийн дарга Бан Ги Мүн “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн нь дэлхийн дулаарлыг 2 хэмээс доош хязгаарлах Парисын хэлэлцээрийн зорилгод Монгол Улсын оруулж буй бодит хувь нэмэр гэдгийг онцолж, сүүлийн 10 жилд уур амьсгалын өөрчлөлт, Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх ажил шинэ түвшинд гарсныг тэмдэглэхийн сацуу, цаашид бүгд ах дүүс мэт хамтран, гар нийлж ажиллахыг уриаллаа.

Энэхүү үйл хэрэгт шинэ судалгаа, инновац, шинэлэг шийдэл, бодлогын түншлэл бий болгож, бүх талыг татан оролцуулах, тууштай байдал чухал болохыг онцлон тэмдэглэв.

2025.06.06



Цэцэрлэгт хүрээлэнгүүд байгуулагдав



“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний нөлөөгөөр нийслэл болон томоохон суурин газруудад цэцэрлэгт хүрээлэн, төгөл, шинэ хороолол, хотхонуудын ногоон байгууламжууд өргөжин тэлж, шинээр байгуулагдаж байна. Энэ нь зөвхөн хотын өнгө үзэмжийг сайжруулаад зогсохгүй иргэдийн байгальд хандах хандлагад шинэ соёлыг төлөвшүүлж байна.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн эхэлснээс хойш 2021-2024 оны хооронд 18 аймгийн 28 сум, Улаанбаатар хотын 6 дүүргийн хэмжээнд 2,006.35 га талбайд цэцэрлэгт хүрээлэн байгуулав.

Эдгээр цэцэрлэгт хүрээлэнд 655,438 ширхэг мод, сөөгийг тарьж, 11.5 га талбайд зүлэгжүүлэлт, 64,056 м² талбайд 3,202,800 ширхэг цэцэгт ургамлаар цэцгийн мандал байгуулаад байна. Эдгээр үйл ажиллагаанд 26.6 мянган иргэн, 1000 орчим аж ахуйн нэгжүүд оролцов.

Сүүлийн жилүүдэд хурим, төгсөлт, ой, төрсөн өдөр, дурсгалт өдрүүдэд зориулан мод тарих үйл ажиллагаа улам бүр дэлгэрч, мод тарих нь хайр, хүндлэл, хариуцлагыг илэрхийлэх арга болон төлөвшиж байна.

Иймд зөвхөн “Мод тарих үндэсний өдөр”-т хязгаарлагдах бус, жилийн аль ч үед бортгонд ургуулсан тарьц суулгацыг тарих боломж бий болсон нь мод тарилтыг өдөр тутмын амьдралын нэг хэсэг болгоход дөхөм болжээ.

Өөрийн эзэмшлийн талбайгүй ч гэсэн ногоон ирээдүйг бүтээлцэхийг хүссэн иргэд, гэр бүл, хамт олон, байгууллагууд нийслэл, аймаг, дүүрэг, сумдын цэцэрлэгт хүрээлэнд очиж мод тарих, арчлах, эсвэл алсаас сонголтоо хийж захиалга өгөн тариулж, арчилгаа, ургалтыг хянах боломж бүрдсэн нь сайшаалтай.

Цэцэрлэгт хүрээлэнгүүдийн заримыг онцлон танилцуулж байна. Эдгээр хүрээлэн бүр өөрийн нөхцөл, журмыг баримталдаг.



ОЛОН УЛСЫН СОЁЛЫН ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН

Монгол Улсын түүх, соёлыг дэлхийд сурталчлан таниулах, гадаад, дотоодын жуулчдын зорин очих орон зайг бүтээн байгуулах, эрүү орчинд ая тухтай амарч зугаалах, ногоон технологийн шийдэлтэй 35 га талбай бүхий амралт зугаалга, боловсрол, чөлөөт цаг, худалдааны зориулалттай.

Цэцэрлэгт хүрээлэнгийн архитектур, орон зайн ерөнхий төлөвлөлтийн хамгийн оновчтой шийдлийг шалгаруулах нийт 55 сая төгрөгийн шагналын сантай зураг төслийн уралдааныг олон улсын хэмжээнд зарлаж, гадаад дотоодын 184 оролцогчоос шалгаруулжээ.

Үндэсний хэмжээний “Модлог ургамлын тарьц, суулгацын үзэсгэлэн худалдаа”-г Монголын мод үржүүлэг, цэцэрлэгжүүлэлтийн мэргэжлийн байгууллагуудын нэгдсэн холбоо, 40 гаруй байгууллагын оролцоотойгоор жил бүр уламжлал болгон амжилттай зохион байгуулж байна. Нийт 512 иргэн, аж ахуй нэгж нийгмийн хариуцлагаа ухамсарлан сайн дураараа цэцэрлэгт хүрээлэнгийн талбайд мод тариад байна.

Төсөл санаачлагч: **Их Үйлсийн Эрэлд Групп ХХК**,
Төсөл хэрэгжүүлэгч: **Туурайн Төвөргөөн ХХК**

ШИНЭ НАЛАЙХ ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН

“Шинэ-Налайх” цэцэрлэгт хүрээлэн нь нийт 68 га талбайтай ба 28.5 га газарт 58154 ширхэг мод, сөөгийг стандартын дагуу тарьж, арчлан ургуулж байна. Нийт талбайн 60 хувьд нь 60-70 мянган мод, сөөгийг дүүргийн ААН, иргэдийн оролцоо, дэмжлэг, өөрсдийн нөөц бололцоогоор ногоон байгууламжийг нэмэгдүүлэхээр ажиллаж байна.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2025 оны байдлаар ногоон байгууламжийг 35.4 га болгон нэмэгдүүлсэн. Налайх дүүргийн нийтийн эзэмшлийн талбайд ургаж буй 97817 ширхэг мод, сөөг, таримал зүлэгжсэн талбайг арчилж дүүргийн хэмжээнд нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээг 9.02м²



болгон дэлхийн зарим хотуудын түвшинд, мод сөөгийн амьдралтыг 97.5 хувьд хүргэжээ.

Facebook хуудас: **“Цэцэрлэгжүүлэлтийн албаны албан ёсны хуудас”** гэсэн хаягаар холбогдон цэцэрлэгт хүрээлэнд мод тарих боломжтой.



“БАЯНГОЛ ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН” ОНӨТҮГ

“Баянгол цэцэрлэгт хүрээлэн” ОНӨТҮГ нь 2021 оноос 2025 оны хавар хүртэлх хугацаанд “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд олон төрөлт ойн төгөл, ургамлан хашлага хэлбэрээр нийт 15 төрлийн 31,674 ширхэг мод сөөг тарьж арчилгаа, усалгаа тогтмол хийж байна. Иргэдийн амралт, чөлөөт цагаа зөв өнгөрүүлэх тохилог, эрүүл, таатай орчныг бүрдүүлжээ.

Энд сурагчдад дадлагад суурилсан экологийн боловсрол олгох, нарийн ногоо хүлэмжийн аж ахуй эрхлэх, монгол орны цаг агаар, орчинд тохирсон мод, бут, сөөг, зүлэг тариалах зэрэг үйл ажиллагааг 41 хүний бүрэлдэхүүнтэй явуулж байна.

Facebook хуудас: **“Баянгол цэцэрлэгт хүрээлэн” хаягаар холбогдон цэцэрлэгт хүрээлэнд мод тарих боломжтой.**



“ИНЧОН МӨРӨӨДЛИЙН ТӨГӨЛ” ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН

Тус хүрээлэнг Улаанбаатар хот, БНСУ-ын Инчон хотын дарга нарын байгуулсан санамж бичгийн хүрээнд газрын доройтлыг арилгаж, цөлжилтийн эсрэг ногоон зурвас байгуулах, иргэдийн амралт чөлөөт цагийн тав тухтай орчныг бүрдүүлэх зорилгоор бүтээжээ. Согинохайрхан дүүргийн Жаргалант тосгоны “хогийн хонхор” гэж нэрлэгддэг байсан хуучин хогийн цэгийн 100 га талбайг 10 жилийн хугацаанд ойжуулах ажлыг 8 дахь жилдээ амжилттай хэрэгжүүлж байна.

“Инчон мөрөөдлийн төгөл” нь “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд 2022 онд нэгдэн орсноос хойш 40 га талбайд бүрэн ойжуулалт хийсэн ба жил бүрийн хавар, намрын улиралд бүх нийтийн мод тарих арга хэмжээгээр 2000 гаруй аж ахуйн нэгж байгууллага, хувь хүн оролцож 12 мянга гаруй мод тарьжээ. Энэхүү цэцэрлэгт хүрээлэнд иргэн, аж ахуйн нэгж байгууллагууд өөрийн нэрэмжит төглийг бий болгож, мод тарих боломжтой.

Хэрэгжүүлэгч: **Нүри ХХК**

Гүйцэтгэх, захирал Зөвлөх агрономич: **Х.Лхагважав**



МОДНЫ ЧУКАГИЙН ДЭЛХИЙН ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН

Д.Эрдэнэчулуун ээжийнхээ дурсгалд зориулж мод тарьж, ургуулах ажлаа эхлүүлж байж. Германы “мод үрчлэх” туршлагыг Монголдоо хэрэгжүүлж байгаа нэгэн билээ. Мод үрчлүүлэх гэдэг нь мод бүрийг эзэнтэй, өөрсдөө ирж тарьж суулгах эсвэл арчилгаа суулгалтын багахан төлбөрийг нь өгөөд захиалгаар суулгах гэсэн хоёр байдлаар мод тарихыг хэлнэ.

Тэрбээр Герман улсад 20 гаруй жил ажиллаж, амьдарч байгаа бөгөөд жил бүр зуны амралтаараа Улаанбаатарт ирж Баянзүрх хайрхны хуучин модтой байсан ар талд Туул голын урд ойжуулах үйл ажиллагаа явуулж байна.

Энэ цэцэрлэгт хүрээлэнд гэр, суварга хэлбэртэйгээр нас барагсдын дурсгалд зориулж мод тарих, жуулчид, гадаадад амьдарч буй монголчууд болон гадаадууд, төгсөгчид 14 мянган мод үрчлэн ургуулжээ.

Түүнчлэн “Модны нууц амьдрал” номыг хамтран монгол хэлээр хэвлүүлээд байгаа бөгөөд ойн тухай баримтат кино орчуулж нийтэд үзүүлэх, хүүхдийн бичил номын сан байгуулах зэргээр иргэд, хүүхдүүдийн тархинд мод тарих соёл сэтгэлгээг суулгах олон ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

Facebook хуудас: [facebook.com/dulamjaverdenechuluun](https://www.facebook.com/dulamjaverdenechuluun)
хаягаар холбогдон хамтран ажиллах боломжтой.



ТҮРГЭНИЙ ГОЛ ДАХЬ ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН, МОД ҮРЖҮҮЛГИЙН ТӨВ

Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 14-р хороо Өлзийт хороололд байрлах Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн Түргэний гол дахь хүрээлэн нь 8 га талбай бүхий 14 төрлийн навчит мод, 3 төрлийн шилмүүст модыг үржүүлээд байна. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн эхэлснээс хойш нийт 100 мянга гаруй

модыг тарьж арчлан ургуулжээ. 2025 оны хаврын мод тариалалтын үеэр 37,155 мод тарьсан байна.

Уг цэцэрлэгт хүрээлэнд иргэд, аж ахуйн нэгжүүд мод тарих боломжтой ба одоогийн байдлаар зөвхөн гоёлын мод тариулж байна.

Сая мод ургуулсан туршлага ХОЁР САЯ ДАХЬ МОДОО ТАРИХ ТЭМҮҮЛЭЛ



*Үгээр урлаж, Үрээр ургуулагч монголчууд
бидний оюун санаа, ой бүтээх үйлийн үлгэрлэл
Чинагийн Галсан манай сэтгүүлд морилло.*

Нэг сая мод битгий хэл нэг ширхэг мод ТАРЬЖ УРГУУЛАХ нь бөөн ажил, багагүй сэтгэл, цаг хугацаа шаарддагийг зуслангийн хашаандаа мод тарьж үзсэн миний туршлага батлах билээ. Бид ТЭРБУМ мод тарьж ургуулах амлалт бас зорилготой ард түмэн ба бидний нэг Чинагийн Галсан САЯ мод тарьж ургуулсан түүх туршлагаа манай сэтгүүлд хуваалцаж байгаа нь сэтгэл хөдөлгөж бахархал төрүүлж байна. Бахархалт хүмүүний хүү Галтайхүү аавынхаа мод тарьж ургуулдаг туршлага, тэвчээр, ноу хау, тэмүүлэл зорилго утга учрыг манай сэтгүүлээр дамжуулсныг уншигч та бүхэндээ уламжилж байна.

Мод тарих нь хойч үедээ үлдээх өв

Миний аав Чинагийн Галсан 2009 онд өөрийн бичсэн номын борлуулалтын орлогоор нэг сая мод тарих зорилго тавьж байв. Германд сурч аялж явахдаа германчуудын мод тарих соёлоос санаа авч Монголын хуурай, цөлжилттэй газар нутгийг ногооруулах хүсэл эрмэлзэл төрж эхэлсэн гэдэг. Мод тарих нь аавын минь хувьд “шүтлэг”, байгаль дэлхийдээ үйлдэж буй буян, хойч үедээ үлдээх өв юм. Аав, миний тарьсан модод бол “миний хөшөө” гэх ба шавар баримал бус урт насалдаг амьд моддыг хойч үедээ өв болгон үлдээхийг өөртөө чухалчилж, бусдад уриалдаг байгаль эх дэлхийдээ нэн хайртай хүн билээ. НЭГ САЯ мод хандивлан тарих зорилго 2022 оны намар биелж, дараагийн САЯ МОД тарих ажилдаа ороод байна.



Мод суулгац хандивлах “Чинагийн Галсан” санг байгуулав

Галтайхүү би аавтайгаа хамтран “Чинагийн Галсан” санг 2007 онд байгуулж, 2009 оноос эхлэн мод тарьж, ургуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж байна. Энэ сан нь мод тарих сонирхолтой хувь хүмүүс, байгууллага, хамт олныг дэмжин ажилладаг ба тарьц, суулгац бэлтгэн хандивладаг.

Сангийн гол санхүүжилт нь аавын минь зохиосон 41 номын борлуулалтын орлогоос бүрддэг бөгөөд 2009 онд 20 мянган хувь борлогдсон номын орлого нь анхны томоохон хөрөнгө оруулалт болж байв. Мөн европын уншигч нарын дэмжлэг болон герман, швейцар найз нөхдийн тууштай дэмжлэг чухал хүч болж ирснийг тодоор тэмдэглэх хэрэгтэй.

“Чинагийн Галсан” сан САЯ МОД хандивлах хүрээнд Улаанбаатар хотын олон сургууль, цэцэрлэг, төрөх эмнэлэг, олон нийтийн газрууд, хувь хүмүүст мод суулгац хандивласан бөгөөд Улаанбаатар хотын Цэцэрлэгт Хүрээлэнг байгуулж байхад 16 мянган мод хандивлаж байсан түүхтэй.



Үрээр нь тарьж ургуулбал бүх мод амжилттай ургана

Унаган мод гэж үрээр нь тарьж ургуулсан модыг хэлж байгаа юм. Хаа нэгтэйд бойжуулсан суулгац биш гэсэн үг. Галсан сангийнхан сая модыг ширхэг бүрийг нь ургуулж амьдруулсан хамгийн гол ноу хау бол үрээр тарьж ургуулсан явдал билээ. Уулнаас мод авчирч шилжүүлэн суулгахын оронд үрээр бэлтгэсэн тарьц, суулгацыг ашиглах нь жинхэнэ мод ургуулалт юм.

Модны амьдрах чадварыг энэ эхлэл тодорхойлдог гэж болно. Мод тарихад баримтлах гурван нөхцөл бий.

Үүнд:

Мал орохооргүй хашаа, хамгаалалттай байх.

Усалгааны худаг, гол зэрэг усны эх үүсвэртэй байх.

Арчилж, хамгаалах манаач, хүн хүчтэй байх.

Бас шар хуайс ус сайн татдаг, хар цагаан хэл ам, өвчин зовлонгоос хамгаалдаг тул монголын уламжлалыг даган хашаа бүрд шар хуайс тарихыг аав минь зөвлөдөг юм.



Нэг хүн сая мод тарьж чадсан юм чинь мянган хүн тэрбум мод тарьчихаж чадна

Миний аавын ургуулж хандивласан унаган модод Монгол улсын 17 аймагт ургаж байна. Монголын өнцөг булан бүрд өдөр өдрөөр ургаж, үржиж буй сая ширхэг модыг ургуулсан уудам сэтгэл, нөр их хөдөлмөрийг үнэлж Хөдөлмөрийн баатар цолыг 2023 онд аавд минь монголын төр хүртээсэн юм.

Мод тарьж, ургуулах нь аавын хувьд зүгээр нэг мод тарьж ургуулах үйл байхаа нэгэнт больсон билээ. Тарьж ургуулах энэ үйлийг тэр “соёл, сэтгэлгээний хөдөлгөөн” гэж тодорхойлдог болтлоо хөгжүүлээд байна. “Нэг хүн сая мод тарьж чадаж байхад мянган хүн тэрбум мод тарьж чадна” гэж аав хэлдэг. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн зорилгодоо хүрэхэд хялбархан гэдгийг баталж буй мэт надад санагддаг юм.

Тарьсан мод бүрт зөв арчилгаа, хамгаалалтын хашаа, усалгааны систем шаарддаг. Жижигхээн үр том мод болж ургах хүртэл аав анхаарч халамжилдаг гэж болно. Ингэхдээ орон нутгийн унаган модны үрийг ашиглах, олон нийтийн дэмжлэгийг татах зэрэг нь сая мод ургуулсан түлхүүр гэж аав хэлсэн юм.

Монголын эрс тэс, хуурай уур амьсгал, мал идэж гэмтээх, усны хомсдол зэрэг нь мод тарихад тулгардаг гол бэрхшээл байдаг. Гэсэн хэдий ч “Зорилготой хүн хүйтнийг хүйтэн, халууныг халуун гэж цааргалдаггүй” гэдгийг өөрийн бүтээсэн ногоон жимээрээ нотлон харуулсан ааваараа би бахархдаг.

Аймаг, нийслэл 56 САЯ МОД ТАРИВ

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд 21 аймаг, нийслэл нэгдэж нийт 680 сая мод тарьж ургуулах амлалт өгсөн.

2025 оны эхний хагас жилийн байдлаар Улаанбаатар хот, аймгууд 56 сая мод тарьж, гүйцэтгэл 11.45 хувьтай байна. Эдгээрээс Сэлэнгэ аймаг 23.9 сая мод тарьж амлалтаа давуулан биелүүлсэн бол Төв аймаг 4 сая, Орхон аймаг 3.6 сая, Хэнтий аймаг 2.1 сая мод тарьж бусдыгаа манлайлав.



СЭЛЭНГЭ АЙМАГ

Тэрбум модны амлалтын биелэлтээр манлайллаа

Тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөнийг Сэлэнгэ аймгийнхан боломж хэмээн хүлээн авав. Сэлэнгэ аймгийн иргэд өмнө нь Тужийн нарсыг ойжуулсан арвин туршлагатай. Тиймдээ ч 2022 онд улсын хэмжээнд 9.2 сая ширхэг тарьц, суулгацын нөөцтэй байсны 8 сая тарьц, суулгац нь тус аймаг бүрдүүлжээ.

Сум болон сум дундын Ойн анги, сумын Засаг дарга нараас 2022-2030 онд “Ойжуулах, ойн зурвас байгуулах, бургасжуулах талбайн байршлыг тогтоох тухай” тогтоол гаргуулсан нь анхны томоохон ажлын нэг байлаа.

Ойжуулалт, ойн зурвас байгуулах ажилд 16.4 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, Ойн салбарт өмнө нь байгаагүй их санхүү хөрөнгөөр Үндэсний хөдөлгөөн эхэлснээс хойш 23.9 сая мод тарьж, ургууллаа. Ингэснээр бэлтгэл шатандаа “АМЛАЛТАА БИЕЛҮҮЛСЭН АНХНЫ АЙМАГ” болов.

ТӨВ АЙМАГ

20 сая мод тарих амлалтын гүйцэтгэл 20 хувьд хүрч улсдаа аман хүзүүдлээ

Ойн бодлогын хүрээнд “Тэрбум” мод үндэсний хөдөлгөөнд нэгдэж 20 сая мод тарьж ургуулахаар төлөвлөж 2025 оны эхний хагас жилийн байдлаар 4 сая мод тарьж ургуулснаар бусад аймгуудаа манлайлж явна.

2025 оны тооллогоор аймгийн хэмжээнд 13 сумын 28 мод үржүүлгийн аж ахуйн нэгж 75.8 сая ширхэг тарьц суулгац үр болон мөчрөөр үрслүүлэн ургуулав.

Аймгийн жил бүрийн үзэсгэлэн худалдааны үеэр Төв аймагт үйл ажиллагаа явуулдаг мод үржүүлгийн аж ахуйн нэгж, нөхөрлөлүүд тухайн нутгийн хөрсөнд бойжуулсан орон нутгийн онцлог, цаг уурын нөхцөлд тэсвэртэй стандартын шаардлага хангасан тарьц суулгацаар идэвхтэй оролцдог.

Мөн мод тарьж, арчлан ургуулах 76 сургагч багш бэлтгэгдэн 53 удаагийн сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулж 1936 иргэнд мод тарих мэдлэг олголоо.



ӨМНӨГОВЬ АЙМАГ

Мод тарьсан хүн бүрд урамшуулал олгож элс шороон шуурганы эсрэг хамгийн үр дүнтэй ажиллаж байна

Өмнөговь аймаг 2005 оноос эхлэн цөлжилтийг сааруулах, хэт халалтыг багасгаж тав тухтай орчин бүрдүүлэхэд иргэн бүрийн оролцоог хангах, дадал хэвшил бий болгох зорилгоор өөрийн хашаандаа мод тарьж ургуулсан айл өрхөд мөнгөн урамшуулал олгох ажлыг эхлүүлж байв.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн эхэлснээс хойш үйл ажиллагаагаа улам эрчимжүүлж, урамшууллын журмаа шинэчлэн тогтоож айл өрх 9 ширхэг мод, аж ахуйн нэгж, нөхөрлөл 90 ширхэг ба түүнээс дээш тооны мод тарьснаар урамшуулал авах эрх нээгдэж мод бүрийн үнэлгээг эхний жил 3000, хоёр дах жил 4500, 3 дах жил 6000, нийт гурван жилийн хугацаанд 13,500 төгрөгөөр тооцож урамшуулал олгож байна. Ингэхдээ иргэдэд мод тарьж ургуулах заавар зөвлөгөөг тухай бүрд нь хүргэдэг.

Тус аймгийн хэмжээнд 2021-2024 оны хооронд 511 айл өрх, аж ахуйн нэгж нийт 196,250 ширхэг мод тарьж ургуулан орон нутгийн төсвөөс 624.1 сая төгрөгийн урамшуулал авсан ба Гурвантэс сум хамгийн олон мод тарьжээ.

Урамшууллын хүрээнд Гурвантэс сумын иргэн Төмөрбаатарын Мөнхсайхан 2023 онд 7963 ширхэг, 2024 онд 28796 ширхэг заг тарьж хамгийн олон мод тарьсан иргэнээр тодорч 80,5 сая төгрөгийн мөнгөн урамшуулал авчээ.

Хашаандаа мод тарьсан айл өрх урамшуулалд хамрагдах хүсэлтээ баг, хороондоо мэдэгдсэнээр аймгийн Байгаль орчны газар, сум дундын ойн анги, сумын ЗДТГ, иргэний төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг тухайн иргэн, ААНБ-ын тарьсан модыг газар дээр нь тоолж актаар баталгаажуулдаг байна.

Өмнөговь аймаг 70 сая мод тарих амлалт өгсөн ба 2025 оны байдлаар нийт 1.2 сая мод тарьж биелэлт 2.7 хувьтай явна. Модны урамшуулал мод тарих ажлыг улам бүр эрчимжүүлж ирэх жилүүдэд биелэлтээрээ манлайлахыг хүсье.



ХЭНТИЙ АЙМАГ

30 сая мод хөтөлбөр хэрэгжүүлж байна

Хэнтий аймгийн нийт нутаг дэвсгэрийн 21.7 хувийг ойн сан эзэлж байна. Ойн сангийн талбайн хэмжээгээр улсын хэмжээнд Хөвсгөл, Булган, Сэлэнгэ аймгуудын дараа дөрөвдүгээрт ордог.

Аймгийн хэмжээнд “Гучин сая мод” хөтөлбөр хэрэгжүүлэх хүрээнд 2022-2024 онд мод үржүүлгийн газар, тоног төхөөрөмж, худаг, усалгааны системийг шийдвэрлэж, үрийн нөөцийг бүрдүүлснээр 10.4 сая суулгац бэлтгэжээ.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд аймгийн нийт ойн сангийн талбайг 0.05 хувиар, нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн талбайг 135 га-р тус тус нэмэгдүүлж, 2025 оны байдлаар аймгийн хэмжээнд ногоон байгууламж, хамгаалах ойн зурвас болон ойжуулалтаар нийт 2.1 сая мод тариад байна.

Говьд 30 мянган заг тарьж ургуулан 80.5 сая төгрөгийн урамшуулал авав

Өмнөговь аймгийн Гурвантэс сум хамгийн олон мод тарьж аймагтаа тэргүүлжээ. Тус сумын хөдөлмөрч, сэтгэл зүтгэлтэй иргэдийн оролцоо ийн амжилтад хүргэсэн нь гарцаагүй. Учир нь ширхэг мод бүрийг ургуулан амьдруулж, түүнийгээ жил бүр тоолуулан, сайхан ургуулсан модныхоо тоогоор мөнгөн урамшуулал авдаг энэ үйл ажиллагаа үр дүнтэй хэрэгжиж буйн нотолгоо юм. Гурвантэс сумын иргэн **Төмөрбаатарын Мөнхсайхан** 2023 онд 7963 ширхэг, 2024 онд 28796 ширхэг заг тарьж хамгийн олон мод тарьсан иргэнээр тодорч 80.5 сая төгрөгийн мөнгөн урамшуулал авчээ.



Юуны өмнө та уншигчдад өөрийгөө танилцуулаач?

За би Өмнөговь аймгийн Гурвантэс сумын уугуул иргэн. Нутагтаа хань дөрвөн хүүхдийнхээ хамт сайхан амьдарч байна. Миний ханийг Н.Отгонзул гэдэг. Бид хоёр 2010 оноос 2019 хүртэл мал маллаж, бас хувиараа ажил хөдөлмөр эрхэлж байлаа. Хүүхдүүдийн маань түрүүч нь окуутан болоод явсан. Тэгээд 2019 оноос сонирхлоороо мод тарьж эхэлсэн. Ах дүүс, хамаатан, найз нөхөдтэйгөө хамт Гурвантэс сумандаа заг үржүүлж, үржүүлсэн загаа өөрсдөө ойжуулалтад гаргаж байв. Үүнээс хойш одоогоор ойжуулалтад гаргасан 30 мянга гаруй загтай болсон байна.

Та хаана ямар ямар төрлийн мод тарьж байгаа вэ?

Манайх 2022 онд мод үржүүлэх, мод тарих чиглэлээр компани байгуулаад, ойжуулалтын тусгай зөвшөөрөлтэй болсон. Тэгээд орон нутаг, улсын төсвийн тендерт оролцоод говийн бүсдээ заг тарих хоёр ажилд шалгарч хэрэгжүүлсэн. Авсан гурван төслийн маань хоёр нь биеэ даасан. Нэгийг нь одоо арчлаад явж байгаа. Өдрөөр цалинждаг ажилтан нэмж аваад ажиллуулдаг. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 15 мянган заг, өнгөрсөн жил улсын төсвийн хөрөнгөөр Булган суманд 18 мянган заг, хоёр мянган хайлаас гэх мэт 22 мянган мод, Гурвантэс сумандаа 16 мянган заг тариад байна.

Харин урамшуулалд хамрагдаад явж байгаа 36 мянган заг байна. Энэ жил гурав дахь жил нь гүйцэж байна. Бас загны суулгац борлуулж ийш тийш нь бага багаар нийлүүлж байгаа. Нийтдээ 100 мянга орчим мод тарьжээ. Түлхүү заг тарьсан.



Танайх модны урамшууллыг их эртнээс олгож эхэлсэн. Яаж тооцож олгодог юм бэ?

Манай аймаг мод тарилт, таримал ойгоороо улсдаа тэргүүлдэг. Мод их тарьдаг аймаг шүү дээ. “Ногоон хэрэм” зэрэг олон улсын төсөл амжилттай хэрэгжиж байсан. Анх 2004 онд Иргэдийн хурлаар баталж хэрэгжүүлж ирсэн санагдаж байна. Нэг модонд 4500 төгрөгийг 3 жилийн хугацаанд олгож байсан. Тэгээд 2023 онд шинэчлэн батлаад нэг модонд 13,500 төгрөг болгож нэмэгдүүлсэн. 3 жилийн хугацаандаа хувилж хуваагаад олгодог.

Модны арчилгаага та өөрөө хийдэг үү?

Тийм. Улсын төсвөөр тарьж байгаа моднуудынхаа хашаа хайс, усалгаа, арчилгааг нь шийднэ. Хавраас намар болтол хүмүүс ажиллуулж зөөж усална. Бороо ер нь ховор ордог. Гандуу болохоор дандаа зөвөрийн усаар л усалдаг. Ус хуримтлуулах боломж тун муу. Харин урамшуулалд хамрагддаг моддоо өөрийн хөрөнгө санхүүжилтээр хийдэг.

Та мод тарьж ургуулахад хэчнээн хөрөнгө мөнгө зарцуулав. Тооцож үзэж байсан уу?

Тэгж нарийн тооцож үзээгүй л явна. Улсын төсвөөр хэрэгжүүлж байгаа нь бол тодорхой. Хувиасаа өөрийн талбай дээр тарьж байгаа модныхоо санхүүг харин тооцож байгаагүй юм байна. Ер нь мод тарьж ургуулахад санхүү их шаардана. Ус худагны асуудал шийдэх нь хамгийн чухал байдаг. Манайх машинаар усаа зөөвөрлөж усалдаг. Эхний хоёр жил нь худаггүй байсан болохоор 4 км-ийн зайнаас усаа зөөж усалдаг байлаа. Аймаг маань мод тарьсан иргэнээ дэмждэг болохоор манай талбайд орон нутгийн төсвийн хөрөнгөөр худаг гаргаж өгсөнд нь их баярлаж байгаа. Бас 5 тоннын усны машинтай.

Та хамгийн өндөр урамшуулал авсан иргэнээр тодорсон. Говьд мод ургуулах амаргүй шүү дээ?

Эхний жилдээ 30 сая, хоёр дахь жилдээ буюу 2024 онд 80.5 сая төгрөгийн урамшуулал авсан. Энэ жил 28 мянган модны урамшуулал авахаар тоолуулаад

байгаа. Жилдээ 30 мянга орчим мод тоолуулах төлөвлөгөөтэй байна. Болж өгвөл нэмэгдүүлнэ дээ. Модны урамшуулал өндөр авахаар эргэн тойрондоо ч бас сайнаар нөлөөлж байх шиг. Манай найз С.Даваахүү гэхэд 20 га газар аваад энэ жил 20-иод мянган мод тоолуулж байна. Аймагтаа хоёрт орсон. Гэх мэтчилэн уул уурхайд мод тарьж өгдөг хүмүүс ч олон болж байна.

Ер нь их л тэвчээр шаардсан ажил шүү. Туршлагагүй, өөрсдийн санаачилгаар ах дүүс, найзаараа нийлж тарьж байсан болохоор их тэвчээр, санхүү шаардаж байсан. Одоо бол учраа олоод туршлагажаад байгаа. Мод тарих ажлыг ахуй амьдралтайгаа холбосон болохоор мэрийж ажиллаад суулгасан үр бүхнээ мод болгохыг зорьдог.

Сар бүр урамшуулал авдаг юм уу? Модныхоо урамшууллаар амьдраад байж болж байна уу?

Маш сайхан шүү дээ. Орон нутагт ажлын байр хомс байдаг. Өөртөө ажлын байр гаргаж ирээд цалинтай адил урамшуулал авч байна гэдэг сайхан. Малчин



хүн малаа маллаад үр шимийг хүртдэгтэй адил модоо тариад амьдраад байж болж байна. Орон нутгаас тарьсан модыг маань жил бүр тоолж, хянана. Яг хэдэн мод тарьж ургуулж гээд харж байж мөнгөө өгнө. Тэгэхээр моднуудаа амьд сайхан ургуулж байж л урамшууллаа авна. Ургаагүй үхсэн бол нөхөн тарилтаа хийнэ. Жилийнхээ услалтыг хийнэ. Сайн арчилна. Нэг талдаа гэр бүлдээ ажлын байр бий болгож нөгөө талдаа улам хариуцлагатай байхыг шаарддаг.

Өнгөрсөн жил тоолсон юм чинь энэ жил хамаагүй гээд орхихгүй. Жил бүр модоо тоолуулна. Намар 9,10 дугаар сарын дундуур намрын тооллого хийдэг. Хавар нь манайх тэдэн мод тоолууллаа, тэдэн мод урамшуулалд авах хүсэлтэй байна гээд аймаг сумын Байгаль орчны газартай гэрээгээ хийдэг.

Гэрээний дагуу мод нь байгаа эсхийг Аймгийн байгаль орчноос мэргэжилтнүүд ирж тоолоод баталгаажуулдаг. Тэгж байж л урамшуулал орно. Эхнэр маань миний хамгийн сайн хамтрагч. Сүүлийн гурван жил мод тарих ажилдаа л 100 хувь төвлөрч байна. Өөр ажил хийгээгүй.

Өвөл 11 дүгээр сараас хойш сумын төв рүүгээ гэртээ ирдэг. Үржүүлгийн 3400 мкв газартай. Тэндээ үрээ үржүүлж суулгацаа тариалалтад гаргадаг. Шууд ойжуулалт гарахгүй ээ. Үрээ 1-2 жил арчлаад хүлээнэ. Жилдээ 30-40 мянган суулгац бэлтгэдэг.

Мод тарих газраа яаж сонгодог вэ?

Анх бол мэдлэг байгаагүй. Тэгээд аль болох шороон шуурга ихтэй тал дээр л элсний нүүдлийг хамгаалж тарьдаг байсан. Цаг

уурын нөхцөл нэлээн хүнд. Хавар 4-7 сар болтол өдөр бүр л шуурна шүү дээ.

Манайх нийтдээ 118 га газар хашаажуулж 30-аад га талбайд нь мод тариад байгаа. Нийтдээ 160 мянга гаруй мод тарих зорилготой ажиллаж байгаа. Говьд хамгийн тэсвэртэй мод нь заг. Ойжуулалтад гаргасан байхад үхнэ гэж байхгүй. Ингэхийн тулд 3 жил орчим шаардана. Тэгээд ойжуулалтад гарсны дараа жилдээ гурван удаа сайтар усалдаг. Амьдрах хувь нь их өндөр. 90 хувьтай.

Таны цаашдын зорилго, мөрөөдөл юу вэ?

Хашаалсан талбайгаа дүүргэнэ гэсэн зорилгодоо ямартай ч хүрнэ. Дүүргэхэд бас их хугацаа орно. Жилдээ 30-40 мянган суулгац бэлдэж байна. Тэрийгээ ойжуулалтад гаргаад хагас нь хорогдоно. Нөхөн тариалалт хийнэ гэж явсаар 30 мянган загийг 2021 оноос одоог хүртэл тарьж байна. Тэгэхээр ямартай ч 10-аад жил байна. Заг маань ургаад нэг үеэ бодвол шуурга шорооны хамгаалалттай болсон. Одоо нөмөрт нь хайлаас зэрэг навчит мод тарих санаатай байгаа. Хүнсний ногоо тарих боломж муухан. Элс шороогоор шуураад дарчихдаг болохоор зохимжгүй. Жимсний мод бол ургаж мэднэ. Турших гээд л явна. Ер нь суулгасан моддын маань 80 гаруй хувь нь амьдарч амжилттай ургаж байгаа.

Урамшууллаасаа зардлаа суутгаад ашиг гэж гарах уу?

Нарийн бодоогүй. Манайх ганцаараа биш ах дүүсээрээ нийлсэн хэдэн айл байдаг юм. Ээлжлээд модоо харж, арчилна. Урамшууллаа гаргасан зардлаараа тооцоод хуваагаад авдаг. Манайд бол болж байгаа. Онцлог нь жилдээ нэг удаа цалингаа авна. (инээв) 12 сарын сүүлээр бөөнд нь нэг өгдөг.

“Цөлжилт Монголд” гэрэл зургийн уралдаан
Зурагчин Н.Батсүх. 2021 он



Дэлхийн эх газрын 40 гаруй хувь нь доройтолд өртөөд байна. Иймд дэлхийн улс орнууд цөлжилттэй тэмцэх, түүний эрчийг сааруулах зорилгоор 1994 онд “Ган цөлжилтөд ноцтой нэрвэгдэж буй орнууд цөлжилттэй тэмцэх тухай” НҮБ-ын конвенцыг баталж, 195 улс орон нэгджээ. Манай улс 1996 онд цөлжилттэй тэмцэх конвенцыг соёрхон баталсан эхний 50 улсын нэг болсон.

Монгол Улс дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн эрчимтэй өртөж байгаа 10 орны нэг

Монгол улсад цөлжилт эрчимтэй явагдаж, цөлийн бүс хүрээгээ тэлсээр байна. Манай орны нийт нутаг дэвсгэрийн 76.9 хувь нь дундаас дээш зэрэглэлийн цөлжилтөд өртсөн.

Үүнээс хүний буруутай үйлдэл 87 хувь, уур амьсгалын өөрчлөлт, байгалийн хүчин зүйлсээс шалтгаалсан нь 13 хувь, газар зүйн байршил, эх газрын эрс тэс уур амьсгал зэргээс үүдэн дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн эрчимтэй өртөөд байгаа 10 орны нэг нь манайх.

Сүүлийн 80 жилийн уур амьсгалын ажиглалтаар Монгол орны хэмжээнд дундчилсан байдлаар жилийн агаарын температур 2.25 хэмээр дулаарч, хур тунадасны хэмжээ 8 хувиар буурчээ.

Ой модны хууль бус ашиглалт, хүнд үйлдвэрүүд, хөрс хуулалт, элс, хайрга олборлолт, харцуцлагагүй уул уурхай, бэлчээр, азрын талхагдал, хөдөө орон нутгийн олон салаа зам харгуй, хөрсний бохирдол зэрэг нь газрын доройтол, цөлжилтөд хамгийн ихээр нөлөөлдөг.

Монгол Улс цөлжилттэй тэмцэх чиглэлээр сүүлийн жилүүдэд олон улсын байгууллагуудтай хамтран ажиллахаар хичээж байгаа. 2022 оны арваннэгдүгээр сард Монгол Улс Европын Холбоотой ойн салбарын тогтвортой менежментийн чиглэлээр хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурснаар Европын холбооны Ойн түншлэлд нэгдэн орсон Азийн анхны орон болсон.

Түүнчлэн, Монгол Улс 2026 онд НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцын Талуудын 17 дугаар бага хурлыг (COP17) зохион байгуулахаар төлөвлөж байна. Тус хурлыг зохион байгуулж байгаа нь цөлжилтийн асуудлаар дэлхийн хэмжээнд дуу хоолойгоо хүргэх, цөлжилттэй тэмцэх олон улсын хамтын ажиллагааг идэвхжүүлэх, энэ салбарт хөрөнгө оруулалт татахад чухал ач холбогдолтой хэмээн үзэж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн бол цөлжилттэй тэмцэх гол ажил.

Хууль хүчний байгууллагууд МОД ТАРИВ

2025 оны хаврын тоон мэдээгээр төрийн байгууллагуудаас Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар (ШШГЕГ) хамгийн олон буюу 2.3 сая мод тарьсан бол Батлан хамгаалах яам 1.6 сая, Хил хамгаалах ерөнхий газар 379 мянган мод тарьж бусдыгаа манлайллаа.



ШШГЕГ-ын алба хаагчдыг Агроэкологийн сургуульд ойжуулалтаар сургав

Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд ШШГЕГ-ын даргын 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн А/152 дугаар тушаалаар “100 сая мод тарих хөтөлбөр”-ийг баталсан.

Хөтөлбөрийн хүрээнд 2022-2025 оны эхний хагас жилд системийн хэмжээнд нийт 2.3 сая мод тарьж, арчлан ургуулж байна.

Түүнчлэн ХААИС-ийн “Агроэкологийн сургууль”-д ойжуулалтын чиглэлээр 51 алба хаагчийг сургалтад хамруулж, гэрчилгээ олгов. Мөн хорих ял эдэлж буй 1170 хүмүүжигчийг “Ойжуулалт”, “Агро-Ойжуулалт”, “Таримлын агротехнологи”, “Усалгаа”, “Бордоо”, “Ургамал хамгаалал”, “Арчилгаа”-ны чиглэлээр цахим сургалтад хамруулан, мод тарих ажилд татан оролцуулж байна.

“100 сая мод тарих хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхээр салбар нэгжийн бие бүрэлдэхүүний нэгдсэн тарилтыг Сонгинохайрхан дүүргийн Таширын аманд уламжлал болгон зохион байгуулж, жил тутам 2500 гаруй алба хаагч 2500 мод тарьжээ.

Батлан хамгаалах яам 27 сая мод тарих амлалтаа хэрэгжүүлж байна

Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбаруудыг “Эко-ноогоон хотхон” болгон, мод үржүүлгийн газруудын үйл ажиллагааг эрчимжүүлэх, уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, газрын доройтлыг бууруулах зорилтуудыг биелүүлэхээр 27 сая ширхэг мод тарих амлалт өгсөн.

Амлалтаа хэрэгжүүлэхээр Байгаль орчин, экологийн албатай болж, Мод үржүүлгийн сургалтын төвийг байгуулжээ. 35 га талбай бүхий таван мод үржүүлгийн газарт 2.1 сая мод бут үрслүүлжээ.

Мөн “Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”-ий хүрээнд модны тоог бүртгэх зорилгоор www.army-terbummod.gov.mn веб программыг зохион бүтээж, өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглаж байна.

ХААИС-тай хамтран 27454 алба хаагчдад экологийн боловсрол олгох сургалтад хамруулав.

Тавантолгой – Зүүнбаян чиглэлийн төмөр замыг элсний нүүдлээс хамгаалах зорилгоор 250 м урт, 8 м өргөн талбайг хашаажуулж, усалтын систем байгуулан 360 мод, бут сөөгийг тарьж уг төслийг эхлүүлээд байна.




Хилчид ногоон хэрэм байгуулж байна

Хил хамгаалах байгууллагаас “Ногоон хэрэм” төсөл хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд Дорноговь, Сүхбаатар, Дорнод аймгийн хилийн хэсэгт 960 га талбайг хамарсан хамгаалалтын ойн зурвас байгуулж, 1.5 сая ширхэг тарьц, суулгац бойжуулж, Говь-Алтай, Баянхонгор, Өмнөговь, Дорноговь, Сүхбаатар аймагт 178.7 га талбайд нийт 437,871 ширхэг мод тарьж, хээрийн ойжуулалт хийлээ.

2022 онд 516 хугацаат цэргийн алба хаагчдыг ойжуулагч бэлтгэх сургалтад хамруулж, мэргэжлийн үнэмлэх олгов.

Цаашид аймаг орон нутагт 92,400 навчит модоор хамгаалалтын ойн зурвас байгуулах, 250 мянган ширхэг заг, шинэс модоор ойжуулалт хийжээр төлөвлөжээ.



Мод тарьж ургуулах нөлөөллийн аяны мэдээлэл давхардсан тоогоор 155.3 сая хандалт авав

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдэн 2021-2030 онд “Нэг сая мод” тарих үүрэг, амлалт авч, төлөвлөгөө гарган хэрэгжүүлж байна.

2021-2025 онуудад давхардсан тоогоор 26,661 алба хаагч төв орон нутгийн 966 байршилд нийт 400,951 мод тарьж, хэрэгжилт 30.0 хувьтай хангагджээ.

Иргэд, олон нийтийг уриалах мэдээлэл сурталчилгаа, нөлөөллийн ажлын хүрээнд “Тэрбум мод-Байгалиа бүтээе”, “Зөв мод зөв арчилгаа”, “Хүн бүр байгаль хамгаалагч”, “Хашаандаа мод тарья” зэрэг нийт 8 удаагийн аяныг улсын хэмжээнд нэгтгэн зохион байгуулав. Аяны хүрээнд бэлтгэсэн контентыг орон сууцны лифт, төв, орон нутгийн зар сурталчилгааны лед дэлгэц, телевиз, сайт, сонин сэтгүүл, фм радио, зам дагуух CCTS, Billboard, автобусны буудлын JC-Desaих самбар, нийслэл, орон нутгийн зорчигч тээврийн автобус, арилжааны банкны АТМ, Киоск машин, интернэт банк, төрийн үйлчилгээний E-Mongolia, EBarimt апплейкшн, үүрэн холбооны оператор компанийн масс мессеж, IPTV олон сувгийн үйлчилгээ эрхлэгч зэрэг дижитал, Gorilla маркетингийн сувгийг бүрэн ашиглаж, түгээжээ.

Нийт 1066 мэдээ, мэдээлэл бэлтгэн цахим орчинд түгээсэн нь давхардсан тоогоор 155.3 сая хандалт буюу Монгол Улсын нийт хүн амд тооцвол 1 хүнд 38.5 удаагийн давтамжтай хүрснээр иргэд, олон нийтийн дунд мод тарьж, ургуулах соёл дэлгэрч, эерэг дадал хандлага, мэдлэг ойлголт бий болов.



МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН ЗӨВЛӨГӨӨ



Анхлан мод тарьж байгаа хүн ямар мод тарих вэ?

Байгаль орчны гавьяат
ажилтан, “Танайд мод тарья”
ТББ-ын тэргүүн

Б.Батболд

Нэгдүгээрт төлөвлөлт хийхдээ анхаарна. Хоёрдугаарт модны ботаник мөн чанарыг нь судалж мэдэх хэрэгтэй. Таны тарих гэж байгаа мод хэр өндөр ургадаг, хэдэн настай болох юм, өндөр ургах үед та хэдэн настай байх уу, таны үр хүүхдэд үлдэх үү, үгүй юу гэдгийг нь судлаарай. Жимс жимсгэнийн бут тарилаа гэхэд өрхийн хэрэгцээний хэдэн хувийг нь хангах юм, үүгээр хагас боловсруулсан бүтээгдэхүүн хийхэд ямар орлого олж болох юм гэдгээ нарийн тооцоолно.

Монголд 140 төрөл зүйлийн мод ургадаг. Таны цэцэрлэгт дор хаяж 60-70 хувийг нь монголд нутагшсан үндсэн модод эзэлнэ. Үлдсэн 30 хувь нь гоёл чимэглэлийн болон жимс жимсгэнийн мод байвал зүгээр. Бас нэг зүйл нь мод тарьж буй хэн бүхэн ая тухтай орчныг бий болгоход анхаараарай.



Мод тарих нүхийг хэрхэн бэлтгэх вэ?

Монгол- Солонгосын хамтарсан
“Ногоон хэрэм” төслийн ахлах
менежер

Ч.Одсүрэн

Өмнөговь болон Лүн дээр ойжуулалт хийж байхдаа модныхоо нүхийг урд жил нь ухсан. Тэгээд тогоон дотор хөрсний үржил шимтэй хэсгүүд салхиар дамжаад ороод ирдэг. Тодорхой хэмжээгээр хөрсөн дээрх ургамлын үлдэгдэл бас хийсэж орно. Ингэж урд жил нь нүхээ ухчих юм бол арай илүү хөрс нь баяждаг. Нөгөө талаар хөрсний чийг алдагддаг болохоор нүхээ шууд ухсан даруйдаа модоо таривал дээр гэсэн ойлголт байдаг. Гэхдээ үгүй. Хөрс хэчнээн хуурай байсан ч ухаад мод тарихдаа хангалттай сайхан усалж, цаашид тогтмол усалгаатай явдаг учраас хөрс хатах асуудалгүй. Харин хөрсөө баяжуулахыг хүсвэл урд жил нь ухвал илүү сайн гэдгийг бид туршилтаар баталсан.



Модны тарьц суулгацыг хэрхэн сонгох вэ?

Монгол улсын зөвлөх агрономич, "Говь Голден Сийдс" ХХК-ийн зөвлөх

С.Тунгалаг

Хүмүүс аль болох өндөр, том мод авна гээд байдаг. Гэтэл намхан ч байсан хамаагүй үндэсний системийн хөгжил сайтай мод авч байж тэр ургамал илүү сайн шилжин сууж, ургахдаа ч сайн байна. Амьд мод дарахад зөөлөн байдаг. Ургасан модоо барьж үзээд мөчир нь хатсан хатуу байвал хэлбэршүүлээд авч болно. Нахиа задраагүй, үндэсний систем сайтай ургамлыг ямар зориулалтаар тарих нь чухал. Ойжуулалтад гаргах юм уу эсвэл хашаандаа хэлбэржүүлж тарих гэж байгаа зэргээс шалтгаалж сонгоно. Багаас нь буюу 40-50 см өндөртэй, титэм үүсэж эхэлж байгаа мод л авч тарина. Хамгийн гол нь үндсийг сайн харах хэрэгтэй. Модны 50 хувь нь хөрсний доор байдаг учраас үндэс чухал.

Бас бүс нутгаасаа хамаарч ялгаатай. Иймд гарал үүсэл, бүс нутгаас хамаарч ямар тарьц суулгац бэлтгэхээ мэргэжлийн хүмүүсээс зөвлөгөө аваарай. Хангайд навчит модод, говьд хур тунадас багатай учраас хаалтын үндэсний системтэй бортоготой мод тарихыг зөвлөдөг. Яг тухайн орчинд байгаа моддыг л тарина.



Мод усалгааг хэрхэн хийх вэ?

Монголын байгаль орчны иргэний зөвлөлийн тэргүүн, Чинагийн Галсан сангийн тэргүүн

Г.Галтайхүү

Анхны усалгааг мод тарьсан даруйдаа хийнэ. Хамгийн багадаа 40-50 литр ус хийх ёстой. Ингэж байж мод шинэ суусан газраа дасна. Тэгээд 7 хоногт багадаа 2 удаа 20-40 литр ус хийнэ.

Харин хаврын усалгааг дөрөвдүгээр сар эхлээд л хийж эхэлнэ. 7,8 дугаар сараас хойш усаа бага багаар татна. Бид байгалийн хуулийг л дагана гэж ойлгох хэрэгтэй. Байгаль дээр 4,5 дугаар сараас эхлээд цас хайлж, бороо орж хөрсөндөө чийг өгдөг. 8 дугаар сараас бороо татарч, 10 дугаар сард хүйтрэхэд мод маань өөрөө өвлийн бэлтгэлдээ орж нахиагаа хумьж эхэлдэг. Нахиагаа хумьж эхлэхээр нь усалгааг 7 хоногт нэг, тэгээд хоёр долоо хоногт нэг хийж усаа татсаар байгаад хүссэн хүсээгүй мод нахиагаа хумина. Ингээд 10 дугаар сард хасах хэм рүү орох үед сайн услаад хөлдөөчих хэрэгтэй. Намрын энэ цэнэг усалгааг 10 дугаар сар гараад шөнөдөө -5 хэм болоход нэг модонд багадаа 40-50 литр ус хийж, ус нь сайн шингэж байвал дахиад хоёр гурав хоногийн дараа нэмж хийгээд хөлдөөнө. Ингэж байж ус нь үндсэндээ хангалттай хүрч, шөнийн хасах хэмд хөлдөн, хавар болтол гэсэхгүй. Тэгвэл дараа хавар газар гэсэж мод сэргэхэд хөлдсөн ус нь үндсэндээ цэнэг усалгаа болж маш сайн чийг өгдөг.



Модыг хэзээ тарих вэ?

"Монголын ой судлалын нийгэмлэг" ТТБ-ын гүйцэтгэх захирал, доктор, ойн инженер

З.Цогт

Хавар дөрөвдүгээр сарын сүүлээр мод тарьж эхэлнэ. Мод тарих гэдэг байгаль экологитой шууд хамааралтай. Шөнийн температур +5 хэмээс дээш болсон тохиолдолд өвс ногоо, мод бут бүгд нахиаалж цэцэглэдэг. Энэ бол биологийн ургамлын хууль. Тэгэхээр +5 хэмээс дээш гарсан тохиолдолд модоо тарьж болно. Хасах хэмд мод тарих юм бол ургахгүй, үхнэ. Хүлэмжид бол тарьж болно. Өдөр нь нээгээд, шөнө нь хаагаад. Үүнийг мэдэхгүйгээс болж хүмүүс хэт эрт эсвэл хэт орой тариад мод үхээд байдаг.

Мод үржүүлэгчдийн тоо 32% нэмэгджээ



“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн хэрэгжиж эхэлснээс хойж тарьж ургуулж байгаа мод, тарьц суулгац, үрийн нөөц, мод үржүүлгийн газрын тоо, хэмжээ өмнөх жилүүдээс 5-6 дахин нэмэгдлээ.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг бодит үр дүнд хүргэхэд мод үржүүлгийн аж ахуйн нэгжүүдийн оролцоо, чадавх нэн чухал. Амьдрах чадвар сайн тарьц суулгац нийлүүлэх нь зөвхөн бизнес биш, харин ногоон хөгжлийн салшгүй хэсэг юм.

Орон нутаг, нийслэлд үйл ажиллагаа явуулж буй мод үржүүлэгч аж ахуйн нэгжүүд бүс нутгийн онцлогт тохирсон мод, сөөгний төрөл зүйлийг үржүүлэн, суулгацын нөөц бүрдүүлж, ойжуулалт, нөхөн сэргээлтийн бодлогыг газар дээр нь хэрэгжүүлэгч гол түншүүд болоод байна.

Мод үржүүлэх иргэн, нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын тоо 32 хувиар нэмэгдэж (2024 оны байдлаар) 452 газар болсон байна. Эдгээр газрууд 124 зүйлийн 63 сая орчим тарьц суулгацын нөөц бүрдүүлсэн нь тэрбумаар тоологдох мод тарьж ургуулах нөөц бүрдүүлэх бүрэн боломжтойг баталгаажуулав.



Үндэсний хөдөлгөөний хүрээнд мод үржүүлгийн үйл ажиллагаа эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгжийн холбогдох техник, тоног төхөөрөмжийг гааль, НӨАТ, газар болон ус ашигласны төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх чиглэлээр холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан.

НӨАТ-аас чөлөөлөх тухай хуулийн дагуу 2021-2025 онуудад импортоор болон дотоодод борлуулж байгаа ойн аж ахуйн техник, тоног төхөөрөмж, хүлэмж, усалгааны тоног төхөөрөмж, бордоо ургамал хамгааллын бодисыг худалдан борлуулахад нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлж байна.

Ингэснээр 2021-2023 онуудад 25 аж ахуйн нэгжид 49.8 тэрбум төгрөгийн татвараас хөнгөлөөд байна.

Мөн Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 419 дүгээр тогтоолын 2 дахь хавсралтаар 2 дугаар хэсэгт өөрчлөлт оруулан ургамал тарьж ургуулах замаар байгалийн баялгийг нөхөн сэргээх зориулалтаар ус ашигласан тохиолдолд газрын доорх болон гадаргын ус ашиглах төлбөрөөс 100 хувь чөлөөлсөн билээ.

“Бугант нандин” ХХК мод үржүүлэг, тарилтаараа хувийн хэвшлийн байгууллагуудыг МАНЛАЙЛАВ

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хувийн хэвшлийн дотроос “Бугант нандин” ХХК 3 сая мод тарьж ургуулан манлайлан ажиллаж байна.

Тус компани 2007 оноос эхлэн мод үржүүлэг, ойн нөхөн сэргээлт буюу ойжуулалт, газрын хэвлийн нөхөн сэргээлт, мод боловсруулах чиглэлүүдээр үйл ажиллагаа явуулж буй ур чадвар, дадлага туршлагатай инженер, ажилтан, албан хаагчид бүхий ойн мэргэжлийн байгууллага юм.

Мод үржүүлгийн хамт олон “ТЭРБУМ МОД” үндэсний хөдөлгөөн хэрэгжиж эхэлсэн 2022 оноос мод үржүүлгийн газрыг нэмэгдүүлж монгол орны цаг уур нөхцөлд тохирсон 17 төрөл 350-500-аад кг

навчит болон шилмүүст модны үрийг тарьж, багагүй хэмжээний тарьц суулгац бойжуулж байна.

2023 оноос хойш ТЭРБУМ МОД үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх зорилгоор 1600 кг орчим модны үрийг мод үржүүлгийн газруудад тариалав.

Ерөнхийлөгч санаачилсан ТЭРБУМ МОД үндэсний хөдөлгөөн, Сэлэнгэ аймгийн засаг даргын тамгын газрын хамтын ажиллагааны хүрээнд 1237.9 г-д ойжуулалт хийж 3 сая 57 мянган ширхэг навчит болон шилмүүст модоор ойжуулалтын ажлыг хийжээ.

2024 онд “Тэрбум мод” сантай хамтарсан төслийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Хушаат, Алтанбулаг, Дархан-Уул аймгийн Хонгор сумуудад сая гаруй шилмүүст, навчит модоор ойжуулалт хийж, доройтсон ойн нөхөн сэргээх ажлыг амжилттай гүйцэтгэв.



Дэлхий дахинд усны нөөцөө үр ашигтай удирдах сорилт тулгарав



Завхан аймаг
Богд голын хүрхрээ
Зурагчин Ж.Доржпүрэв. 2021 он

Хүн амын хурдтай өсөлт, уур амьсгалын өөрчлөлт, хотжилт зэрэг олон хүчин зүйлийн нөлөөгөөр усны хэрэглээ жил бүр эрчимтэй нэмэгдэж байна. Жишээлбэл, 2050 гэхэд дэлхийн хүн амын тоо 9.8 тэрбумд хүрч, усны хэрэглээ өнөөгийнхөөс даруй 20-30 хувиар нэмэгдэх тооцоо гарчээ (НҮБ 2019).

Түүнчлэн хотжилт эрчимтэй явагдсанаар цэвэр усны хүртээмжийн тэнцвэр алдагдаж, хүн ам болон цэвэр усны нөөцийн жигд биш тархалттай холбоотойгоор ойрын хэдэн арван жилийн хугацаанд дэлхийн олон улс оронд цэвэр усны нөөцийн хомсдол нүүрлэх төлөвтэй байна. Улмаар дэлхий даяараа усны

нөөцөө үр ашигтайгаар удирдах томоохон сорилттой тулгараад байна.

Дэлхий нийтийн туршлагаас харахад усны хомсдол нь хоол хүнсний гачигдал, уснаас үүдсэн бүс нутгийн чанартай мөргөлдөөнүүд, эдийн засгийн өсөлт удааширах, байгаль орчны доройтол зэрэг олон хямралын эх үүсвэр болж байдаг. Иймээс ойрын жилүүдэд цэвэр усны хүртээмжийг сайжруулах нь улс орнууд, дэлхий нийтийн нэн тэргүүнд анхаарал тавих, шийдвэрлэх асуудал болоод байна.




Монгол орны ус ашиглалт, сая.м³/жил

Салбар	2021	2022	2023	2024
Хөдөө аж ахуй	339.2	338.6	337.5	300.5
Уул уурхай	113.4	92.5	171.1	161.3
Унд, ахуй	84.5	86.3	88	89.4
Эрчим хүч, дулаан	41.5	46.2	46.6	36
Үйлдвэр, ахуйн үйлчилгээ	16.2	42.6	35.9	30.7
Нийт	594.8	606.2	679.1	617.9

Салбаруудын ус ашиглалт

2021-2024 оны дундаж



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

“НЭГ СУМ НЭГ НУУР” ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТЭЗҮ БОЛОВСРУУЛЖ БАЙНА

Монгол орны усны нийт нөөц 564.8 км³ бөгөөд үүний 19.4 км³ нь мөнх цас, мөсөн хуримтлал, 34.6 км³ нь гол мөрөн, 500 км³ нь нуур тойром, 10.8 км³ нь газар доорх ус эзэлдэг.

Монгол орны гол мөрний усны нөөцийн 70 хувь нь Алтай, Хангай, Хэнтийн нуруу, Хөвсгөлийн уул, Их Хянганы нуруу зэрэг уул нуруудын өндөрлөг хэсэгт бүрэлддэг.

- Гол мөрний урсац бүрдэх эх талбай **143,998.8 км²**
- Монгол орны нийт нутаг дэвсгэрийн хэмжээ **9.1%**
- Улсын тусгай хамгаалалтад авсан талбай **71,949.05 км²** байна.

Монгол орны ус ашиглалтыг салбар бүрээр авч үзвэл 2022 онд нийтдээ 606.2 сая метр³ ус ашиглажээ. Үүний 31 хувийг мал аж ахуйн салбарт, 25 хувийг усалгаатай газар тариаланд, 15 хувийг уул уурхайн салбарт, 14 хувийг унд ахуйд, 8 хувийг эрчим хүч, дулаанд, 7 хувийг үйлдвэр, ахуйн үйлчилгээний салбарт ашигласан байна.

“Алсын хараа 2050” урт хугацааны бодлогын баримт бичигт тусгасан гол мөрний урсац бүрэлдэх эхийг хамгаалах зорилтод 2025 онд гол мөрний урсац бүрэлдэх эхийн 55 хувийг, 2030 онд 60 хувь, 2050 онд 75 хувийг хамгаалалтад авахаар тусгажээ.

2023 онд улсын хэмжээнд 4,415.0 га усны сан бүхий газарт хохирол учруулсан ба хамгийн их хохирол учруулсан талбайд гадаргын болон гүний ус бохирдсон 203 га (46%), мал болон хүний үйл ажиллагаанаас булаг шанд, худаг ойр орчмын газар бохирдсон 167.5 га (38%), ашигт малтмалын олборлолтоос эвдрэлд өртсөн эрэг хавийн газар 71 га (16%) байна.

Мод тарьж ургуулахад шаардагдах усны нөөцийг бүрдүүлэх, ялангуяа гадаргын усыг говийн бүс нутаг руу шилжүүлэх, хөв цөөрөм байгуулах,

усалгааны хэмнэлттэй дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх чиглэлийн хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

- **Гадаргын ус хуримтлуулах боломжтой талбайн байршлын судалгааг Усны газартай хамтран зохион байгуулж байна.**
- **“Нэг сум нэг нуур” төсөл хэрэгжүүлэхээр жишиг ТЭЗҮ боловсруулж байна.**
- **Усалгааны хэмнэлттэй эко хувин турших ажлыг Төв аймгийн Батсүмбэр, Дундговь аймгийн Мандалговь суманд хэрэгжүүлж байна.**

Мөн гадаргын ус хуримтлуулсан хөв цөөрмийг хамгаалах, голын ай сав татмыг ойжуулах ажлыг 2023-2024 онд 16 байршилд 160 га талбайд зохион байгуулаад байна.

Хашаандаа 200 мод тарьж ургуулсан ХОТЫН АЙЛ



Манай улсын нийт хүн амын 46 хувь буюу 1.6 сая иргэн нийслэл Улаанбаатар хотод амьдарч байна.

Нийслэлийн хүн амын 60-аас илүү хувь нь гэр хорооллын бүсэд амьдардаг. Гэр хорооллын 205 мянган айл өрх бүр хашаандаа мод тарихад Улаанбаатар хотын агаарын бохирдол 50 хувиар, зүлэгжүүлснээр тоосжилт 80 хувиар тус тус буурна гэсэн тооцоолол бий.

Тэгвэл энэ буланд хашаандаа мод тарьж ургуулаад зогсохгүй үржил шимийг нь хүртэн амьдарч буй үлгэр жишээ гэр бүлийг танилцуулж байна.

Сонгинохайрхан дүүргийн 1-р хорооны иргэн З.Ваанчиг, гэргий М.Өнөржаргал нар 27 жилийн өмнө хашаандаа анхны нарсаа тарьж байсан нь гурван метр хэртэй өндөр ургажээ.

Өдгөө үхрийн нүд, чавга, мойл, чацаргана, алим, өрөл, долоогоно, улаан интоор гэх мэт жимсний болон навчит, шилмүүст 200-аад мод тарьж ургуулсан нь утаатай Улаанбаатарт баймгүй их хөдөлмөр зүтгэл, сэтгэлээр бүтсэн мэт. Гэрээсээ тав алхаж гараад л сүүдэрт нь сэрүүцэж, шинэхэн үр жимсээр нь ундаалж, өвөлдөө амьд гацуураа чимэглэн, өнгө үзэмж, тав тухыг байгалийн үзэсгэлэнт мод цэцэгсээр бүрдүүлж хашаандаа сайхан амьдарч байна. Тансаг сайхан

Хөрсний арчилгаа

Ойр хавьд мод тарьсан айл цөөн. Шаварлаг хөрстэй тул шавар нь барьчаад ургадаггүй тул бууц, элс, ялзмагтай хар шороотой багсарч хөрсөө бэлтгэдэг байна. Зүгээр айлын хотонд байгаа бууцнаас шууд авчраад хийх юм бол үндэс түлэгдэнэ. Нэлээд өнжсөн нэг, хоёр жил бүр гурав дөрвөн жил болсон хөнгөрчихсөн хөх бууц ашиглаарай.

Жимсний мод тарихад анхаарах зүйлс

Жимсний мод тарихад суулгацаа яаж тарихаас шалтгаална. Шууд нүхэнд суулгаж болохгүй. Хөрсөө сайн бэлтгэж, судалж байж шийдэх хэрэгтэй. Хар шороон хөрс зарим газар 20, 30 см байдаг хөрсөнд гүн суулгаж болохгүй. Доошоо шавар хөрсөнд хүртэл ухаж болохгүй, шимт хөрсний хэмжээнд үндэс тарахаар суулгавал зүгээр.

Нүхийг хэт том ухаж болохгүй 50-60 см радиустай ухахад боломжийн.

Суулгац хаанаас хэрхэн сонгох вэ?

Өнжсөн бортогуу уу эсвэл бортоголоод удаагүй зарж байна уу гэдгээс л их хамаардаг. Бортоголоод удаагүй мод ургац муутай. Гол нь үндсийг харах хэрэгтэй. Дэлбээлээгүй байхад нь суулгаарай. Дэлбээлсэн байвал ургалт муутай байдаг.

Усалгаа

Усалгааг гүний худгаар шийддэг. Худгийн хүйтэн усаар усалбал ургамлын өсөлтийн хурд багасдаг. Тиймээс усаа усан оргилуур руугаа хийж 1-2 хоног өнжөөж бүлээсгэсний дараа усалгаанд ашигладаг. Өөрийн байшин болон урд айлынхаа дээрээс борооны ус тосож авах, усны дусал бүхнийг хуримтлуулж ашиглахыг

хичээдэг. Худгийн ус хатуулаг ихтэй, борооны ус зөвлөн байдаг учраас мод услахад маш хэрэгтэй.

Арчилгаа

Эхний 2 жил л сайн арчлаад ургуулчихад арчилгаа багасаад явдаг. Гэхдээ жимсний мод арчлахгүй орхиж болохгүй жил бүр хавар цэцэг гараад ирэхээр түүнийг нь хамгаалах хэрэгтэй. Үхрийн нүд 4-5 кг хураана. Чавга бас сайн ургана. Хортон шавжаас сэргийлэхийн тулд шохойдсон.

Талалт, тайралт

Талбайн голын моднууд 3-4 м өндөр байсныг бусад чавга, үхрийн нүдний мод, шинээр үрээр тарьсан шинэ моднууддаа нар үзүүлж жимсний болцыг сайжруулахын тулд тайрдаг. Жимсний модны мөчрийг замбараагүй ургуулбал нэг нэгэндээ саад болж



амьдрал гэдэг энийг л хэлэх буй за.

Мод тарих бодол байдаг ч хаанаас хэрхэн эхлэх, яаж тарих учраа нэг л олохгүй, үйлдэл болгоогүй яваа хот суурин газрын өрхүүддээ Ваанчиг, Өнөржаргал нар үнэ цэнтэй, бодит туршлагаа хуваалцлаа.

Эхлээд мод тарьж байхад өдөр бүр хараад удаан ургаад байгаа юм шиг сэтгэгдэл төрдөг. Шилмүүст мод эхлээд удаан ургадаг ч нэг эрчээ аваад ургахаар урамтай маш хурдан өндөр болдог. Мод ургахгүй шарлаад байвал урам хугарч шантарч магад. Тиймээс эхлээд арчилгаа багатай мод тариад үзээрэй. Тэгж байж урам ордог. Дараагийн мод руугаа үе шаттайгаар арчилгаатай нарс, жимсний мод тарихыг зөвлөлөө.

салхинд нэг нэгнийхээ цэцгийг гөвж унагаахгүйн тулд тайрах хэрэгтэй. Ер нь замбараагүй ургуулбал үсээ засуулаагүй хүн шиг харагддаг учраас өнгө үзэмждээ анхаарч хэлбэржүүлэн тайрдаг. Том улиас, хайлаасыг тайрахаар илүү өтгөрдөг бас насжилт уртасна. Ялаа шумуулыг цөөрүүлэхэд бас хэрэгтэй.

Газарт орвол яах вэ гэж үү?

Газарт орлоо гэхэд үндэс нь тарчихсан моднуудыг аваад явахгүй орхиод л явах хэрэг болно. Тиймээс модны үнэлгээний асуудал чухал. Сайжруулах хэрэгтэй санагддаг.

Вөвлөжүүлэх

Өндөр салхи хаасан мөнх ногоон нарс моднуудтай тул цас орлоо гэхэд салхиндаа нөмөрлөөд шуураад алга болдоггүй хунгарлаад үлддэг. Цас орохоор талбайн цасаа цуглуулж шүүрдээд жимсний моднуудаа цасаар хучиж дулаалдаг.

Мод ургахгүй байх шалтгаан

Арчилгаа тааруу хийснээс болно. Хотын цэцэрлэгжүүлэлт, мод зулгэн дээгүүр зарим хүмүүс хамаагүй гишгэлээд хүний хөдөлмөрийг хүндлэхгүй байх нь их. Хүмүүсийн сэтгэлгээнд өөрчлөлт оруулахад анхаарах хэрэгтэй санагддаг.



“ХАШААНДАА ТАВАН МОД ТАРЬЯ” экологийн аян 2025 дуустал үргэлжилнэ

Байгал орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас “Хашаандаа таван мод тарья” аяныг санаачлан хэрэгжүүлж эхэллээ. Хот суурин газрын агаарын бохирдол, тоосжилт, дуу чимээний бохирдлыг бууруулах, иргэдийн тав тухтай амьдрах орчныг бий болгох байгалийн шилдэг шийдэл бол мод тарьж ургуулах явдал.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд иргэдийн экологийн боловсролыг нэмэгдүүлэх, мод тарьж ургуулах дадал хэвшлийг суулгах нь энэ аяны зорилго юм.

Аяны хүрээнд мод үржүүлэг, мод тарьж ургуулах үйлчилгээ үзүүлдэг жижиг, дунд, бичил бизнес эрхлэгчид, хүсэлт гаргасан айл өрхүүдийг зөвлөгөө, арга аргачлал, тарьц суулгацаар хангаж буй.

Одоогийн байдлаар Улаанбаатар хотын 7 дүүргийн гэр хорооллын 9225 айл өрх, 16 аймгийн 32 сум хамрагдаад байна. Аян энэ оны 12 дугаар сарын 25 хүртэл үргэлжилнэ.

Хүсэлтээ өгөх: **И Монголиад хүсэлтээ илгээх**

Урамшуулал: **И монголиа-аас авах төлбөртэй үйлчилгээг үнэ төлбөргүй авах**

Хүсэлт гаргагчид тавигдах шаардлага:

- Хүсэлт илгээх иргэний оршин суугаа хаягийн мэдээлэл зөрүүгүй байх
- Тарьсан модыг шилжүүлэн суулгахгүй байх
- Мод тариулах талбайн зургийг оруулах
- Хүсэлт гаргагчийн хашаа, газар нь өмчилсөн гэрчилгээтэй байх
- Иргэн нэг удаа хүсэлт илгээх боломжтой.



Шашинд мод тарих тухай ямар сургаал, номлол байдаг вэ?



Модонд сүү өргөх биш үндэс рүү нь ус хийж, хүнтэй харьцаж буй мэтээр хүндлэх нь зөв зан үйл

“Тэнгэр тайлал” холбооны тэргүүн

У.Хосбаяр

Монгол бөөгийн ёсонд байгаль эх дэлхийгээ хайрлах, модтой холбоотой олон зан үйл бий. Бөөгийн зан заншил нь эцэг тэнгэр, эх дэлхий, тэнд байгаа амьтай бүхнийг хамгаалагч хэмээх үндсэн философитой.

Уул, ус, мод бут бүхэн амьтай бас эзэнтэй. Тиймээс буруугаар харьцах, буруу хүндлэл үзүүлэх, мод ус бохирдуулж, гэмтээнсээс болж маш олон хүн гэмтэж, ураг удам нь сүйрсэн тохиолдол ч байдаг. Тиймээс байгаль эх дэлхийгээс авсан бүхнээ эргээд төлөх учиртай.

Бөөгийн тангарагт “Хангай хайлаас, хад чулууг хөндөхгүй” гэсэн зарчим байдаг. Гагцхүү хүндлэн явах нь зохистой. Хүмүүс мод тахиж байна гээд сүү өргөөд, хадаг уяад байгаа нь тахихаас илүү үхүүлж буй хэрэг. Үнэхээр зан үйл хийхээр бол үндэс рүү нь ус хийж, үрд нь мөргөж эрч энерги авч, хүнтэй харьцаж буй мэтээр шивнэх нь таны сэтгэлийг хөнгөрүүлж, тайвшруулах буй за.

Тайгын бөө нар маш эрч энергитэй байдаг гэж ярьдаг нь модтой ойрхон байж, тэндээс асар их эрч энергийг мэдэрдэгт оршино. Үүний адил модонд ойрхон байхад хүнд маш их эрч энерги сэлгэгдэж, тархи толгой цэнэглэгддэг.

Хүн бүр мод тарьж ургуулан үр хойчдоо үлдээх нь магадгүй зам мөрийг засаж, ирээдүй нь сайн сайхан гэрэл гэгээтэй явах үүд нээгдэнэ буй. Мод тарьж ургуулдаг хүмүүсийн аж амьдрал сайн сайхан явдаг. Учир нь мод ургуулснаар булаг шанд сэргэж, экологийн олон янз байдал бүрэлддэг. Энэ үйлийг дээд тэнгэр хүчтэйгээр урамшуулдаг юм шүү.



Нэр алдар, удмыг тань залгах үйл бүтээе гэвэл МОД ТАРИАРАЙ

“Мекке” сүмийн тэргүүн
Р.Жанарбек

Коран сударт амьд организм, Аллахын

бүтээсэн бүхнийг хайрлан хамгаалж, түүнээсээ маш их таашаал авч, хүндэтгэж, энэрэнгүй байх тухай заасан байдаг. Үүний дотроос мод тарихыг их буянтай ажил, харин ургаж буй ургамал модыг тасдаж хаях нь өөрийн биеэс нэг эрхтэн тасдаж хаясны адил гэж үздэг.

Хэрэв мод суулгасан бол арчилж хамгаалах нь Аллахын өмнө хүлээсэн бас нэгэн үүрэг болдог. Исламын шашин хоёр урсгалтай. Хоёул дээд тэнгэрийг шүтнэ. Уул ус бүгдийг хайрлаж хамгаалах нь бидний үүрэг. Энэ ертөнц дэлхий байхгүй болох үед гартаа атгасан нэг модны мөчрийг ч газарт нь суулгаад яваарай гэдэг. Биднээс хойших үе ирэхэд ертөнц дэлхийд элдэв байгалийн үзэгдэл тулгарвал хүн, ан

амьтад суулгасан тэр мод мөчрөөс амралт, таашаал, агаар усыг ялгаруулж авах тийм ирээдүйг бодож өгүүлсэн сургаал юм. Настай хүн жамаараа насан эцэслэхэд нутаглуулсны дараа хойтох нь буян болог гээд нэг мод суулга гэсэн сургаал ч бий.

Казах үндэстнүүдийн гол зарчим нь өдөр шөнө тэнцсэн хаврын баяр Наурызын өдөр бүх юм амилдаг учраас мод суулгах нь сайн үйл хэмээдэг. Коран судрын сургаалд ч байдаг. Иймээс ханш нээх өдөр мод суулгах үйлс хийдэг заншилтай. Энэ хорвоогоос явахын цагт таны ард үлдэх нэр алдар, удмыг залгах үйл бүтээе гэвэл “төгөл бий болгоорой”. Нэг мод ч гэсэн тариарай. Үр удам тань миний өвөг дээдсийн суулгаж ургуулсан мод хэмээн хайрлана. Тарьсан модныхоо сүүдэрт ач зээ үр хүүхэдтэйгээ суух тийм өдрийг чин сэтгэлээсээ хүсэн мод тариарай.



Зургаан жил газраа хагалж ургацаа хураа, долоо дахь жилдээ амраагаарай

“Амьд үг” Христийн чуулганы ахлах пастор

Л.Батболд

Библид онцолж хэлсэн нэгэн гайхалтай модны тухай өгүүлдэг. Энэ нь Библийн Илчлэлт номд “Амийн модны тухай” ярьсан байдаг. 12 төрлийн үр жимс ургуулан сар бүр жимсээ боловсруулж буй амийн мод байлаа. Тэр модны навчис нь үндэснүүдийг эдгээхийн тулд байв. Нэг ёсондоо тэр модноос ургаж соёолсон навч нь үндэснүүдээ хүртэл эдгээх ерөөлтэй. Ийн Библид онцолсон амийн модонд хүн хүрч болохгүй тухай ярьсан бол хоёр дахь онцолж хэлсэн мод нь хүнд амийг өгөх тухай өгүүлсэн байдаг.

Бурхан хүн төрөлхтнийг бүтээхээс өмнө дэлхийг дараа нь модыг бүтээсэн. Үзэсгэлэнтэй сайхан олон янзын мод бүтээсэн тухай өгүүлдэг. Бурхан энэ дэлхий дээр модоор дамжуулж улс үндэстнүүдийг ерөөх, бидний амар амгалан байдал, эрүүл мэнд бүх зүйлтэй холбож байгаль ертөнцийг бүтээжээ.

Библийн ариун бичвэр нь мод тарих байгаль орчинтой холбоотой гурван зүйлийг хэлсэн байдаг. Бурхан эхлээд байгаль дэлхийг бүтээж, тэр сайхан ертөнцөө хүнийг амьдруулж, дараа нь хүн төрөлхтөнд өгсөн хамгийн анхны үүрэг даалгавар нь байгаль орчноо хамгаалж, арчлан ургуулаад үр шимийг нь хүртэх тухай юм.

Гурав дахь зүйл нь экологийн тэнцвэрт байдлыг хадгалахын тулд байгаль орчноо хамгаалж арчлаж түүний дотор “амраах” тухай ярьдаг. Тиймээс Библийн хуучин гэрээний Левит номд “6 жил газраа хагалж ургацаа хураа, долоо дахь жилдээ амраагаарай” гэсэн байдаг.

Хүн төрөлхтөн байгалиас зөвхөн авах биш арчлах, хамгаалах, мод тарьж ургуулах нь Бурхны хүсэл, Библийн зарчим юм. Христийн мэндэлсэн баяраар ногоон гацуурыг чимэглэдэг учир шалтгаан нь “мөнх амийн тухай” өгүүлдэг. Ногоон гацуур хэзээ ч үл гандах мөнх ногоон амийг илэрхийлдэг. Тийм учраас дэлхий дээрх ургамал, мод, байгаль дэлхий маань бидэнд амь амьдрал бэлэглэдэг гэдгийг ойлгох хэрэгтэй. Амьдарч буй орчиндоо мод тарьж, түүнийгээ чимэглэх нь бурханы бидэнд өгсөн бүтээлийг хамгаалж, хуваалцаж буй бэлгэдэл юм.



Байгалийг хүндэлж л байгаа бол байгаа төрхөөр нь байлгаарай. Идээ будаа өргөх хэрэггүй

Гандантэгчэнлин хийдийн Тэргүүн хамба ламын Ажлын албаны дарга, гавж

Д.Нямсамбуу

Зөвхөн мод гэлгүйгээр хүн хийгээд байгаль дэлхий хоорондын харилцаа, мод тарихтай холбоотой сургаалууд олон бий. Бурханы шашинтан хүн байгальтай хэрхэн харьцах талаар туйлшрал байдаг. Мод, чулуу, байгалийг хэт тахин шүтэх туйлшрал. Тэр нь жаргал зовлонг шийддэг гэж, хүмүүний заяа, хувь тавиланг хаана ч юм байдаг мод, ургамал, хад, ой шийддэг мэтээр ойлгох нь туйлшрал. Бурханы шашныг шүтэн барилдлагын онолоор бүрэн тайлбарладаг. Аливаа зүйл дангаараа оршин тогтнох боломжгүй. Бусдын хүчээр оршдог юм. Тийм учраас бид агаар, ус, мод байж гэмээнэ урт удаан оршино. Энэ зүй тогтлыг нь ойлгож байгаль дэлхийгээ эрхэмлэн дээдэлж хайрлах учиртай. Монгол улс өргөн уудам нутагтай ч тэнцвэрт байдал алдагдаж, хөрс шороо, байгалийн гарц нэлээн эмзэг болсон. Төв азийн хуурай өндөрлөг газар. Хүмүүн бидний үйл ажиллагаанаас хамаарч доройтож байгаа нь маргашгүй үнэн. Иймд Монгол улсаа өнөд удаан байлгахын тулд сүйдэлж хаясан байгалиа сэргээх, мод тарих, хайрлах хүндлэх нь тун чухал байна. Чухал нь модоо ургуулан бойжуулах явдал. Модыг шүт гэхгүй. Хайрлан хүндэл. Танин мэдэхүйн, байгалийн шинжлэх ухааны үүднээс модыг хайрлаж, өсгөн үржүүлэх нь ямар үнэ цэнтэйг ойлгоосой гэж хүсэж байна. Нөхөн сэргээх нь эрхэм үүрэг. Байгалийн баялгаа ашиглаж байгаа бол нөхөн сэргээх нь чухал юм шүү.

Байгалийг хүндэлж л байгаа бол байгаа төрхөөр нь байлгаарай. Тэгвэл байгаль баярлана. Идээ будаа өргөх хэрэггүй. Байгальд будаа чихэр хэрэггүй.

Шинэ Хархорум хотын бүтээн байгуулалтыг албан ёсоор эхлүүллээ

Их эзэн Чингис хааны мэндэлсний 860 жилийн ойгоор Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх дэлхийн үнэт өв, түүх, соёлын дурсгалт газар Орхоны хөндийд шинэ Хархорум хотыг сэргээн байгуулах зарлиг гаргаж, өнгөрсөн хугацаанд хот байгуулахад шаардлагатай бүх судалгаанууд хийгджээ.

2025 оны 06 дугаар сарын 15-ны өдөр Монголчуудын түүхэн уламжлал, хүсэл тэмүүлэл, эв нэгдэл, шударга ёс, цог хийморийн илэрхийлэл болсон Төрийн далбааг Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу “Их хаадын цэцэрлэгт хүрээлэн”-д өнө мөнхөд мандуулах ёслолоор Хархорум хотын бүтээн байгуулалтыг албан ёсоор эхлүүлээ.

Шинэ Хархорум хот байгуулах бүтээн байгуулалтын хүрээнд нийт 1,500 га талбайд 1.2 сая шилмүүст болон навчит мод, сөөг тарьж ургуулах буюу хотын нийт талбайн 50 хувь нь ногоон байгууламж байхаар төлөвлөгджээ.

2025 оны 2-р улиралд төр, уул уурхай, хувийн хэвшил, ойн салбарын 40 гаруй байгууллага, аж ахуйн нэгжийн 800-аад хүн оролцож 700,000 гаруй мод тариад байна. Хотын ойролцоох “Их хаадын цэцэрлэгт хүрээлэн”-д 11,000 орчим мод тарьжээ.

Тарьсан мод тус бүрийг ургуулахын тулд хэсэгчлэн хувааж шаардлагатай хэсгүүдэд гүний худаг, гадаргын



ус, саарал усыг дахин ашиглах замаар усалгааны дуслын систем байгуулж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх Хархорум хотын ногоон байгууламжийн ажилд сэтгэл зүрхээ зориулан, идэвх санаачилга гарган, хөрөнгө зарцуулсан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд ард түмний нэрийн өмнөөс талархал илэрхийллээ.

Шинэ Хархорум хотод 500 мянган хүн оршин суух бөгөөд 285 мянган ажлын байр бий болж, үүнийг даган бүс нутгийн хөгжлийг тэтгэх эко хот болно гэж тооцоолж байна.

Хархорум хот нь түгжрэл, агаар, ус, хөрсний бохирдол гээд нийгэм, эдийн засаг, иргэдийн ахуй амьдрал, эрүүл мэнд зэрэгт сөргөөр нөлөөлж байгаа хүн амын төвлөрлийг задлах, эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөл бүрдүүлэх, нийгмийн суурь үйлчилгээг хангах, суурьшлын шинэ бүсүүд бий болоход томоохон хувь нэмэр оруулах юм.



ТАВИГДАХ ШААРДЛАГА

- ✓ МӨРӨН СУМЫНД ТӨР БИЧИН ХӨРӨГДӨНД ГАЗАР ЭЗЭМЖИХ ГЭРЭЭ ГЭНЧЛЭГЭЭ БҮИЙН ӨРХ БАЙНА.
- ✓ МОД ТАРЬЖ УРГУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНД ОРСВӨРГЧ ӨРХ АЙЛУУДЫГ -НОГ ГЭЛЧМЭЭС ТӨӨДӨХ ТЭГ ӨННӨН СӨНӨЛӨД ТАРЬСАН МОДЫГ ТОО ХАМААРХУЙ ЗӨВХӨН ТУЛАЙН ХАИД ТАРЬСАН МОДНЫ ХӨМЖӨ ХАМААРНА.
- ✓ МОД ТАРЬЖ ӨРХ-НЬ БАЙГАЛД УРГАЖ БАЙГАА МОДЫГ ШИЖУУЛАН СУУЛГАХУЙ БАЙНА. ИЙЛГЭТЭЭР БОЛОН ТАРИАХ ҮЕСАЙ НЬ ТӨДӨРЖИЙГ МОД ТАРЬХЫГ ХӨРИЛСЭН.
- ✓ ТАРЬСАН МОДНЫ УГААТ ЭХНИЙ ЖИД ТЬ АЛС ДОСГАХИЙ 2 ДАХЬ ЖИД 100 КУВЬ УРГУУЛАХ БАЙХ ЗА ҮНЭЭС ДЭСЭГЭЭР УГААТТАЙ ТЭЖИГДӨЛӨД УРАМШУУЛАХ ХАМРУУЛАХ НӨХЦӨЛӨЙГ ХАНГАЛГУУЦД ТӨСӨНӨ.
- ✓ ХАШААНДАА ТАРЬСАН МОД БҮРИЙГ ДУГААРИХ ГЭМЖ ЭҮЭСЭН БАЙНА.
- ✓ УРАМШУУЛАХ ХАМАРДАХ ӨРХҮҮД 6 ШИРХЭГ ЖИМСНИЙ МОД, 6 ШИРХЭГ БУСАД ТӨРНИЙ ӨНДӨР УРГАД МОД НИЙТ 10 ШИРХЭГ МОД ТАРИНА.

МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГИЙН ГАЗАРТ 3-Р САРЫН 20 4-Р САРЫН 20-НЫ ХҮРТЛЭХ ХУГАЦААНД БҮРТГЭНЭ



МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГИЙН ГАЗАРТ 3-Р САРЫН 20 4-Р САРЫН 20-НЫ ХҮРТЛЭХ ХУГАЦААНД БҮРТГЭНЭ

Хөвсгөл аймаг хашаандаа мод тарьсан айл өрхүүдэд УРАМШУУЛАЛ олгож эхлэв

Урамшууллын хугацаа 2025 оны 3 дугаар сараас эхэлсэн ба 2028 оны 9 дүгээр сар хүртэл үргэлжилнэ. Иргэд хүсэлтээ харьяа баг хороондоо бүртгүүлнэ.

Мөрөн сумын 14 багийн Засаг дарга нар мод тарихаар бүртгүүлсэн айл өрхийн бүртгэл судалгааг гаргаж, хашаандаа тарьсан модыг бүртгэн пайзжуулах ажлыг баг бүртгээ зохион байгуулж байна. Мөн мод тарих хүсэлтэй өрхүүдэд зөвлөгөө мэдээлэл хүргэх зорилгоор дадлага туршлагатай ахмадуудыг ажиллуулж ажлын байраар хангаж байна.

Хөвсгөл аймгийн Мөрөн сум хашаандаа 10 ширхэг мод тарьж ургуулсан өрх бүрд 500,000 төгрөг буюу нэг ширхэг модыг 50,000 төгрөгөөр үнэлж урамшуулал олгохоор болжээ.



ОЙН ГАЗАР

Засгийн газрын 2022 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 272 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Ойн газар” байгуулагдсан.

Ойн газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр болон зохион байгуулалтын бүтэц”-ийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022 оны 10-р сарын 13-ны өдрийн А/418

дугаар тушаалаар баталсан.

Ойн газар нь тогтвортой хөгжлийн зорилгод нийцсэн, ойн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх бодлого, хөтөлбөрийн үндэслэл боловсруулах, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Байгаль орчны тогтвортой байдлыг ханган үр өгөөжийг нь өнөө, ирээдүй хойч үе хүртэх нөхцөлийг бүрдүүлж, хүний амьдралын чанарыг сайжруулах

зорилгод нийцүүлэн эко системийн тэнцвэрт байдлыг хадгалах, нөөцийн хомсдол, доройтлыг зогсоох, нөхөн сэргээх, ойжуулах замаар ойгоор бүрхэгдсэн талбайг нэмэгдүүлэх, ойн тогтвортой менежментийг бий болгох талаар төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд мэргэжлийн болон удирдлагын өндөр түвшинд үйлчилгээ үзүүлэх эрхэм зорилгыг биелүүлж байна.

ОЙН САН: 19.103.221 ГА ТАЛБАЙ БУЮУ НИЙТ НУТАГ ДЭВСГЭРИЙН 12.21 ХУВИЙГ ЭЗЭЛЖ БАЙНА

Манай орны нутаг дэвсгэр дээр ургадаг бүх төрлийн мод, заг, бут, сөөг, таримал ойн нөөцөөс Монгол улсын ойн сан бүрддэг. Ой бүхий газар, ойн цоорхой, мод бэлтгэсэн болон ойн түймэр, хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн ойн талбай, түүнчлэн ойн захаас гадагш 100 метр газар, тарьц, суулгац бойжуулах мод үржүүлгийн газрын эзлэх талбай зэрэг нь ойн сангийн газарт хамаардаг.

Монгол орны ой нь Сибирийн их Тайгын үргэлжлэл, дэлхийн гурван томоохон усан хагалбарыг дагаж ургадаг уулын ой юм. Манай орны ой гол мөрний усны нөөцийг зохицуулах, хөрсийг элэгдэл, эвдрэлээс хамгаалах, уур амьсгалыг зөөлрүүлэх, хүлэмжийн хийг шингээх, амьтан, ургамал, бичил биетний амьдрах тааламжтай орчныг бүрдүүлэх, мөнх цэвдгийг тогтоон барих зэрэг экологийн өндөр ач холбогдолтой.

Монгол улсын ойн сангийн талбай 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 19,103,221 га байна. Энэ нь Монгол орны нийт нутаг дэвсгэрийн 12.21 хувийг эзэлж байна. Ойн сангийн талбайг төлөв байдлын хувьд ойн

талбай, ойн бус талбай гэж хоёр ангилал ба ойн талбайг дотор нь ойгоор бүрхэгдсэн талбай, ойгоор бүрхэгдээгүй талбай гэж ангилна.

Ойн сангийн ойгоор бүрхэгдсэн талбай 13,217,327 га байгаа бөгөөд энэ нь нийт нутаг дэвсгэрийн 8.45 хувийг эзэлдэг ба тэдгээрийн 140 гаруй зүйлийн мод, сөөгөөс бүрдэх бөгөөд 83.1 хувийг навч, шилмүүст ой, 16.9 хувийг заган ой эзэлдэг.

Монгол орны ойн нөөц 1,259,025,491 шоо метр байна. Ойн нөөцийн 78.8 хувийг шинэс, 5.1 хувийг нарс, 8.9 хувийг хуш, 0.2 хувийг гацуур, 0.01 хувийг жодоо, 6.0 хувийг хус, 0.17 хувийг улиас, 0.05 хувийг улиангар, 0.01 хувийг хайлаас, 0.3 хувийг бургас, 0.005 хувийг тоорой, 0.14 хувийг заган ойн нөөц эзэлдэг.

Монгол орны ойн сангийн 84.1 хувь нь хамгаалалтын бүсэд, 15.9 хувь нь ашиглалтын бүсэд хамаарч байна. Монгол улсын “Ойн тухай” хуулийн 9 дүгээр зүйл 9.1 заалтын дагуу 9 аймгийн ойн санд ашиглалтын бүс тогтоосон. Ашиглалтын бүсийн ойд сонгон түүвэрлэх огтлолтын аргаар мод бэлтгэхийг зөвшөөрдөг, авч ашиглах боломжит дээд хязгаараас сонгон түүвэрлэх аргаар жилд 11,116 га талбайгаас 270.2 мянган шоо метр модыг үндсэн ашиглалтаар авч ашиглах боломжтой байна.



Хөвсгөл аймаг
Хөвсгөл нуур
Гэрэл зургийн МРА агентлаг. 2022 он



“Тэрбум мод” НҮТББ



“Тэрбум мод” нийгэмд үйлчлэх төрийн бус байгууллага (НҮТББ) нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг идэвхжүүлэх, эрчимжүүлэх, аж ахуйн нэгж, иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, соён гэгээрүүлэх зорилготойгоор 2024 оны 11 дүгээр сараас шинэчилсэн бүтэцтэйгээр байгуулагдан ажиллаж байна.

“Тэрбум мод” НҮТББ нь үндэсний хэмжээнд нөлөө бүхий төсөл, хөтөлбөр санаачлах, олон улсын байгууллага, улс орнуудтай хамтран ажиллах, салбар дундын уялдааг хангах, иргэд, байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, экологийн боловсролыг түгээх, мониторинг хийх чиглэлүүдээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Өнгөрсөн хугацаанд:

- Монголын уул уурхайн ассоциатай хамтран “Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”-ий нэрэмжит чуулга уулзалт;
- “Тэрбум мод” НҮТББ санаачлан, Израил улсын гадаад хэргийн яамны дэргэдэх Олон улсын хөгжлийн хамтын ажиллагааны агентлаг MASHAV-ын дэмжлэгтэйгээр Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудалд “Агч модны төгөл” байгуулах төсөл;
- “2025 онд 150 сая мод тарих зорилгод бид бэлэн үү” сэдэвт ойн салбарын ААН, ТББ-уудыг хамарсан зөвлөгөөн;
- 21 аймгийн төвд байгуулагдах “Тэрбум мод” цэцэрлэгт хүрээлэн санаачилгыг зохион байгуулалтад оролцож байна;



*Бид “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнөөр дамжуулан
ногоон хөгжилд хүрэх гүүр болно.*



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНЖИЙЛӨГЧИЙН
ТАМГЫН ГАЗАР



ТЭРБУМ МОЛ
ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН



www.billiontreesmongolia.com


ТЭРБУМ МОЛ
ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН

*Caragana
arborescens*

ШАР ХУАЙС
МОДНЫ ҮР

ALMAZ
PRESS.